



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЕ ШАТНЫ АЖИЛД
АЛБАН ТУШААЛТНУУДЫН ТАВИХ ХЯНАЛТ СУЛ,
ХАРИУЦЛАГАГҮЙ БАЙДЛААС САНГИЙН ХӨРӨНГИЙН ҮР
ӨГӨӨЖ, ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

АУДИТЫН КОД: ДАА-2025/131-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дархан-Уул аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр
Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн
Утас: 70378845 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Санжаажав
Утас: 70378845 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул
Утас: 70378845 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn

Аудитор Г.Батмягмар
Утас: 70378845 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn

Аудитор Н.Отгонцэцэг
Утас: 70378845 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

Аудитор Н.Хулансүрэн
Утас: 70378845 Цахим хаяг: khulansurenn@audit.gov.mn

Шинжээч З.Мөнгөнцэцэг
Утас: 70378845 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөөд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Сангийн яаманд хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т, Ашигт малтмал, газрын тосны газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нарт тус тус хүргүүлэхийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар (Ш.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар болон Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (П.Баянбаатар), аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нарт тус тус даалгаж, Сангийн сайд (Б.Жавхлан)-д зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийг бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар (Ш.Мөнхбаяр)-т даалгасугай.

5.Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож, тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтаар хадгаламжийн нэгж үүсгэн Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Аудитын багт үүрэг болгосугай.



С. МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaal\2025\EA-In A Tushaal\1230 GAG-6 Docx

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёо	4
Дүрслэлийн товъёо	4
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:	7
БҮЛЭГ 1: ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ИРГЭДИЙН САНАЛААР ДЭМЖИГДЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТАХ-Г ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ ӨНГӨРСӨН ОНООС ӨССӨН БАЙНА	9
1.1 ОНХНС-ийн эх үүсвэр нь татварын орлогын гүйцэтгэлээс шалтгаалан 19,628.1 сая төгрөгөөр дутуу бүрджээ.....	9
1.2. Иргэдийн саналаар дэмжигдээгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдсаар байна	17
БҮЛЭГ 2: ЗАХИАЛАГЧ ШУУД ХУДАЛДАН АВАХ, ХАРЬЦУУЛАЛТЫН АРГЫГ ХЭРЭГЛЭХ ЗОРИЛГООР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙГ ХУВААХ, ШУУД ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЗӨРЧИЛ БУУРАХГҮЙ ДАВТАГДАЖ БАЙНА	26
2.1 Холбогдох албан тушаалтнуудын хяналт сул, хариуцлагагүй байдал нь хууль, журам зөрчигдөх, алдаа зөрчил давтагдан гарах, үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлж байна.....	26
2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 98.6 хувь нь төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрсэн байна	35
2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн 98.8 хувийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна	41
БҮЛЭГ 3: ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ БОЛОН УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД ИЛ ТОД, ҮНЭН ЗӨВ МЭДЭЭЛЭХ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	45
3.1 ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн буюу нийт хэрэгжүүлсэн ТАХ-ний 8.1-18.3 хувьд нь хяналт тавьж ажилласан байна	45
3.2 Удирдлагын мэдээллийн систем, шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн мэдээлэхгүй байгаа нь иргэд олон нийт ил тод, иж бүрэн, үнэн зөв мэдээллийг авч чадахгүй байна.....	50
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	58
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:	58
ЗӨВЛӨМЖ:	59

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж, ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМАТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
БЗД	Баян-Зүрх дүүрэг
БХБХ	Барилга хот байгуулалтын хэлтэс
ГТНАТ	Газрын тосны нөөц ашигласны төлбөр
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 7,986
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЖГҮ	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УМС	Удирдлагын мэдээллийн систем
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХШҮДАХ	Хяналт шинжилгээ-үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНХНС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт	9
Хүснэгт 2	Ашиглалт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын төлөвлөгөө, бүрдүүлэлт, хуваарилалт	10
Хүснэгт 3	ОНХНС-ийн 2024 оны орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл	11
Хүснэгт 4	ОНХС-ийн эх үүсвэр	12
Хүснэгт 5	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-д нэмж төлөвлөсөн эх үүсвэр	13
Хүснэгт 6	ЖГҮ-ний дундаж, олгосон санхүүжилт	14
Хүснэгт 7	Иргэдийн санал өгсөн байдал	17
Хүснэгт 8	Худалдан авах ажиллагааны тоо, мэдээ	26
Хүснэгт 9	Алдаа зөрчлийн харьцуулалт	29
Хүснэгт 10	ОНХС-ийн 2024 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ	29
Хүснэгт 11	Зөрчлийн харьцуулалт	35
Хүснэгт 12	Зорилтот түвшинд хүрсэн байдал	35
Хүснэгт 13	Зорилтод түвшин харьцуулалт	36
Хүснэгт 14	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний ангилал	37
Хүснэгт 15	Хөрөнгийн ашиглалтын байдал	41
Хүснэгт 16	Хөрөнгийн ашиглалтын байдал зэрэгцүүлэлт	42
Хүснэгт 17	ОНХС-ийн хяналт аймаг, нийслэлээр	45
Хүснэгт 18	Шийдвэрийн хэрэгжилтийн хувь	49
Хүснэгт 19	УМС болон судалгааны мэдээллийн харьцуулалт	52
Хүснэгт 20	Удирдлагын мэдээллийн системд мэдээлсэн хувь	52

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ОНХНС-аас олгосон санхүүжилт	11
Дүрслэл 2	2023-2024 оны өвөл-хаврын бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн	14
Дүрслэл 3	Та 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-д саналаа өгсөн талаарх дүрслэл	18
Дүрслэл 4	ОНХС-ийн талаарх мэдээллийг хаанаас авсан талаарх дүрслэл	18
Дүрслэл 5	Аймаг, нийслэлийн чиг үүрэг хувиар	23
Дүрслэл 6	Сум, дүүргийн чиг үүрэг хувиар	23
Дүрслэл 7	Иргэдээс авсан санал, асуулгын дүн	36
Дүрслэл 8	ОНХС-ийн зарцуулалт (чиг үүргээр)	38
Дүрслэл 9	Ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ	42
Дүрслэл 10	ОНХС-ийн ТАХ-ны хяналтын тоо	45
Дүрслэл 11	Захиалагчийн хяналт	47
Дүрслэл 12	Аудитын явцад иргэдээс авсан санал, асуулгын дүн:	53

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан "Аудитын сэдэв батлах тухай" А107, "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд: • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; • Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх асуудлыг тус тус хамруулав.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, баг, хорооны Засаг дарга зэрэг байгууллагуудын аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, түүвэрлэлт хийх, тулган баталгаажуулах, ярилцлага хийж, асуулга авах зэрэг арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: ✓ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт; ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; ✓ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; ✓ Малын тоо толгойн албан татварын тухай хууль;

- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”;
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- ✓ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвөөс 503,483.6 сая төгрөг, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 25,822.6 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

ОНХС-ийн төлөвлөгөө

(сая төгрөгөөр)

№	Аймаг, нийслэл	ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг (Төсвийн тухай хууль 2023.11.10)	ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг (Төсвийн тухай хууль 2024.08.30)	Үүнээс: “Тогтвортой амьжиргаа 3” төслийн урамшуулал	Тодотголоор нэмж батлагдсан дүн
А		1	2	3	4
1	Аймаг	434,295.4	453,316.6	25,822.6	19,021.2
2	Нийслэл	47,781.3	50,167.0	-	2,385.7
Дүн		482,076.7	503,483.6	25,822.6	21,406.9

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх зорилгоор “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн “Удирдлагын мэдээллийн систем”-ийг Сангийн яамны сайтад байршуулсан байна. Энэхүү системд ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг оруулахаар холбогдох журамд заажээ.

Улсын хэмжээнд 2024 онд ОНХС 106,534.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба сангийн эх үүсвэрт нийт 750,543.1 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 574,880.8 сая төгрөгийг бүрдүүлэн тайлангийн жилд ОНХС-аас 523,466.5 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 157,948.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Аймаг, нийслэл нэр	ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл	Нийт эх үүсвэр		Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх зарлагын нийт дүн	ОНХС-ийн харилцах дансны эцсийн үлдэгдэл
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
А		1	2	3	4	5=1+3-4
1	Архангай	3,091.7	17,935.3	14,191.4	14,272.6	3,010.5
2	Баянхонгор	2,931.3	32,528.8	25,955.4	22,215.2	6,671.5
3	Баян-Өлгий	2,857.3	14,892.3	11,765.0	11,639.2	2,983.1
4	Булган	3,618.1	22,629.4	19,061.7	17,731.6	4,948.2
5	Говь-Алтай	2,602.9	21,270.6	18,126.6	15,597.9	5,131.6
6	Говьсүмбэр	2,367.7	9,853.7	7,143.3	8,150.6	1,360.5
7	Дархан-Уул	4,200.1	25,360.5	20,380.9	19,217.4	5,363.6
8	Дорноговь	2,825.2	48,937.7	43,016.4	42,016.1	3,825.5
9	Дорнод	4,903.6	38,515.2	31,256.1	30,903.4	5,256.3
10	Дундговь	4,478.9	22,416.3	16,818.4	13,885.4	7,411.9
11	Завхан	2,751.0	20,762.2	18,663.5	18,735.9	2,678.6
12	Орхон	4,952.2	94,463.2	58,888.7	57,443.5	6,397.4

13	Өвөрхангай	3,560.1	21,123.8	16,402.0	14,386.9	5,575.2
14	Өмнөговь	10,843.3	65,823.4	50,110.6	36,074.3	24,879.6
15	Сүхбаатар	3,697.8	36,650.8	19,932.3	16,781.2	6,848.9
16	Сэлэнгэ	4,587.1	34,782.9	28,733.3	25,729.9	7,590.5
17	Төв	4,315.5	36,990.3	30,340.2	25,235.9	9,419.8
18	Увс	3,327.8	17,643.1	13,904.3	13,431.2	3,800.9
19	Ховд	5,295.0	51,122.9	44,782.2	40,139.4	9,937.8
20	Хөвсгөл	4,353.5	23,109.1	17,963.2	17,806.9	4,509.8
21	Хэнтий	2,105.9	20,771.9	19,268.4	17,518.9	3,855.4
Аймгийн дүн		83,666.0	677,583.4	526,703.9	478,913.4	131,456.5
22	Нийслэл	22,868.3	72,959.7	48,176.9	44,553.1	26,492.1
Нийт дүн		106,534.3	750,543.1	574,880.8	523,466.5	157,948.6

Эх сурвалж: Аудитын нэгтгэсэн судалгаа -АНТАГ

ҮАГ-аас нэгдсэн удирдамжаар 2024 онд “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Монгол Улсын Их Хуралд 1, ЗГХЭГ-т 1, Сангийн яаманд 3, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга нарт 1, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт 2 нийт 8 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аудитын явцад ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн идэвх оролцоо, мэдээлэл ямар байгааг судлах, нэгтгэн дүгнэж аудитын тайланд тусган холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал зөвлөмжийг боловсруулах зорилгоор судалгаа, санал асуулгыг гүүгл форум ашиглан 21 аймаг, нийслэлийн нийт 18,790 иргэнээс цахимаар авч нэгтгэн дүн шинжилгээ хийж, тайланд тусгав.

БҮЛЭГ 1: ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ИРГЭДИЙН САНАЛААР ДЭМЖИГДЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТАХ-Г ТӨЛӨВЛӨЖ ХЭРЭГЖҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ ӨНГӨРСӨН ОНООС ӨССӨН БАЙНА

1.1 ОНХНС-ийн эх үүсвэр нь татварын орлогын гүйцэтгэлээс шалтгаалан 19,628.1 сая төгрөгөөр дутуу бүрджээ

1.1.1 ОНХНС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2¹, 59.1.3², 59.1.5³-т заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 482,076.6 сая төгрөгөөр баталж, 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 21,406.8 сая төгрөг нэмэгдүүлэн 503,483.6 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд 89.1 хувийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ), 2.5 хувийг газрын тосны нөөц ашигласны төлбөр (ГТНАТ), 3.3 хувийг ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, 5.1 хувийг жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас тус тус бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт №1: ОНХНС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт

№	ОНХНС-ийн эх үүсвэр	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	АМНАТ -10%	317,814.3	317,814.3	-	448,481.4	432,328.2	(16,153.2)
2	ГТНАТ-30%	18,850.7	13,388.6	(5,462.1)	12,653.5	9,480.0	(3,173.5)
3	Урамшуулал	15,930.5	15,930.5	-	25,822.4	25,822.4	-
4	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр -100%	4,966.7	4,476.0	(490.7)	3,428.3	3,359.3	(69.0)
5	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр -50%	12,377.1	11,082.1	(1,295.0)	13,098.0	12,865.6	(232.4)
ДҮН		369,939.3	362,691.5	(7,247.8)	503,483.6	483,855.5	(19,628.1)

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн судалгаа

Гүйцэтгэлээр ОНХНС-д төвлөрсөн орлого 96.1 хувьтай бөгөөд өнгөрсөн оноос 33.4 хувиар буюу 121,164.0 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант жилд ОНХНС-д АМНАТ-ийн орлого 16,153.2 сая төгрөг дутуу төвлөрсөн нь улсын хэмжээнд АМНАТ-ийн орлого 1.6 хувиар тасарснаас шалтгаалжээ.

Харин ГТНАТ-ийн орлого 3,173.5 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн нь Ашигт малтмал, газрын тосны газар тайлант оны ГТНАТ-ийн орлогыг 690.3 сая төгрөгөөр дутуу тооцож, Сангийн яаманд хүргүүлснээс ОНХНС-нд дээрх орлогын 30 хувь болох 207.1 сая төгрөгийн орлого дутуу төвлөрчээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Мөн Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын 3.1.3 дахь заалтын дагуу 2024 оны эцэст төвлөрсөн ГТНАТ-ийн орлогын 30 хувь буюу 6,550.3 сая төгрөгийг ОНХНС-д хуваарилаагүй байна.

¹ 59.1.2. Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь,

² 59.1.3 Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг,

³ 59.1.5 Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын гүйцэтгэл 301.4 сая төгрөгөөр буюу дунджаар 98.1 хувиар биелсэн нь зарим аймгийн дээрх орлого тасарснаас шалтгаалжээ.

Харин Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлсэн тайлангаас үзэхэд 2024 оны ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос улсад нийт 41,565.2 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 40.2 хувиар давуулан биелүүлснээр тайлагнажээ.

Шийдвэрлэлт: Ашигт малтмал, газрын тосны газарт “ОНХНС-д хуваарилах газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогыг үнэн зөв алдаагүй тооцоолж байх” зөвлөмжийг хүргүүлэв.

1.1.2 Сангийн Яам ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2⁴, Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 3.1⁵, 3.2⁶-т заасан хувь хэмжээг баримтлан аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр тооцож, хуваарилсан байна.

Аргачлалд заасан нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, ашигт малтмал болон газрын тосны ашиглалтын талбайн хэмжээг харгалзан 276,680.9 сая төгрөг, жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал 25,822.4 сая төгрөг, АМХТЗ-ийн төлбөрөөс 3,428.3 сая төгрөг, АМАТЗ-ийн төлбөрөөс 13,098.0 сая төгрөг, нийт 319,029.6 сая төгрөгийг сум, дүүргийн ОНХС-д хуваарилахаар төлөвлөжээ.

Хүснэгт №2: Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын төлөвлөгөө, бүрдүүлэлт, хуваарилалт

№	Орлогын төрөл	Батлагдсан төлөвлөгөө	ОНХНС-д төвлөрсөн дүн	(сая төгрөг)
				Аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон дүн
1	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого бүрдүүлэлт, хуваарилалт	3,428.3	9,652.3	3,359.3
2	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	13,098.0	14,566.2	12,865.6
Дүн		16,526.3	24,218.5	16,224.9

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн судалгаа

ОНХНС-д 2024 онд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 9,652.3 сая төгрөг, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 14,566.2 сая төгрөг, нийт 24,218.5 сая төгрөг төвлөрсөн хэдий ч гүйцэтгэлээр аймаг, нийслэлийн ОНХС-д 16,224.9 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Аудитаар ОНХНС-д төвлөрсөн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос аймаг, нийслэлд хуваарилсан дүнг тулган шалгахад хайгуулын тусгай зөвшөөрлийн орлого тасарсан 10 аймгийн 25 суманд 131.0 сая төгрөг, ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлого тасарсан 21 аймгийн 70 суманд 304.9 сая төгрөг, нийт 435.9 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

⁴ 59.2.2.энэ хуулийн 59.8-д зааснаас бусад хэсгийн 60 хувийг дараах итгэлцүүрийг харгалзан хуваарилах:

⁵ 3.1.Тухайн төсвийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг тодорхойлоход үндэслэх итгэлцүүрт холбогдох байгууллагаас хамгийн сүүлд гаргасан албан ёсны дараах мэдээллийг баримтална:

⁶ 3.2.Төсвийн тухай хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 10 хувийг мөн хуулийн 59.7-д заасны дагуу тухайн эх үүсвэрийн 20 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймагт тэнцүү хэмжээгээр, 20 хувийг тухайн эх үүсвэрийн 20 хүртэлх хувийг бүрдүүлэх аймагт бүрдүүлсэн хэмжээгээр нь хувь тэнцүүлж хуваарилна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3-т “ОНХС-ийн орлогын шилжүүлгийг тус санг бүрдүүлдэг эх үүсвэрүүдийн орлогын гүйцэтгэлд үндэслэн шилжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ОНХС-ийн 2024 оны эх үүсвэрийг бүрдүүлж буй орлогын гүйцэтгэлээс шалтгаалж, аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 259.7 сая төгрөгөөс 2,124.4 сая төгрөг хүртэл дутуу олгосон байна.

Хүснэгт №3: ОНХС-ийн 2024 оны орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, нийслэлээр

(сая төгрөг)

№	Аймаг, нийслэлийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А		1	2	3=2-1	4
1	Архангай	12,690.8	12,186.4	(504.5)	96.0
2	Баян-Өлгий	11,949.5	11,467.1	(482.5)	96.0
3	Баянхонгор	21,577.0	20,790.0	(786.9)	96.4
4	Булган	14,228.4	13,675.4	(553.0)	96.1
5	Говь-Алтай	17,357.4	16,596.2	(761.2)	95.6
6	Дорноговь	42,708.1	40,852.2	(1,855.9)	95.7
7	Дорнод	25,422.0	24,115.3	(1,306.7)	94.9
8	Дундговь	15,880.4	15,334.9	(545.5)	96.6
9	Завхан	14,700.7	14,095.3	(605.4)	95.9
10	Өвөрхангай	14,480.8	13,880.1	(600.7)	95.9
11	Өмнөговь	47,716.0	46,025.8	(1,690.2)	96.5
12	Сүхбаатар	18,215.7	17,515.4	(700.3)	96.2
13	Сэлэнгэ	27,768.4	26,784.6	(983.8)	96.5
14	Төв	28,366.8	27,395.6	(971.2)	96.6
15	Увс	13,069.0	12,546.3	(522.7)	96.0
16	Ховд	29,385.2	28,327.4	(1,057.8)	96.4
17	Хөвсгөл	16,739.1	16,065.8	(673.3)	96.0
18	Хэнтий	18,587.1	17,914.6	(672.5)	96.4
19	Дархан-Уул	20,763.4	20,023.7	(739.8)	96.4
20	Улаанбаатар	50,167.0	48,042.6	(2,124.4)	95.8
21	Орхон	34,710.3	33,480.2	(1,230.1)	96.5
22	Говьсүмбэр	7,000.3	6,740.7	(259.7)	96.3
Дүн		503,483.6	483,855.5	(19,628.1)	96.1

Эх сурвалж: Сангийн Яамнаас ирүүлсэн судалгаа

Сангийн сайдын 2024 оны 152 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 4-11 дүгээр сард 23,304.8 сая төгрөгөөр дутуу, 12 дугаар сард 3,676.6 сая төгрөгөөр илүү санхүүжүүлж, нийт 19,628.1 сая төгрөг дутуу хуваарилсан байна. Энэ нь ОНХС-ийн эх үүсвэр хугацаандаа бүрэн төвлөрөөгүйгээс шалтгаалжээ.

Дүрслэл №1: ОНХС-аас олгосон санхүүжилт (сараар)



ОНХС-аас олгох орлогын шилжүүлгээс эхний хагас жилд 44.1 хувийг, сүүлийн хагас жилд 55.9 хувийг санхүүжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ ОНХНС-д төвлөрсөн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос аймаг, нийслэлд хуваарилахдаа сумдад орсон орлогын гүйцэтгэлээр бус 435.9 сая төгрөгийг илүү олгосон байна.

Шийдвэрлэлт: Сангийн яаманд ОНХНС-д төвлөрсөн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг аймаг, нийслэлд олгохдоо Сангийн сайдын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу сумдын орлогын гүйцэтгэлд үндэслэн шилжүүлэх зөвлөмжийг хүргүүлэх.

1.1.3 Аймаг, нийслэлийн ОНХС-аас сум, дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг эх үүсвэрийн бүрдүүлэлтээс шалтгаалан дутуу хуваарилсан байна.

Нийслэл 1,275.3 сая төгрөг, Архангай аймаг 504.4 сая төгрөг, Орхон аймаг 1,230.1 сая төгрөг, Дархан-Уул аймаг 2,746.5 сая төгрөг, нийт 5,756.3 сая төгрөгийг ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн батлагдсан хуваариас дутуу, Хэнтий аймаг 10.0 сая төгрөг илүү олгосон байна.

Сангийн яамнаас олгосон орлогын шилжүүлгийг Өвөрхангай, Хэнтий аймгууд сумдад зөрүүтэй олгосон боловч жилийн эцэст бүрэн шилжүүлжээ.

1.1.4 Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2⁷-т заасан эх үүсвэр бүрээр төлөвлөж, нийт 750,543.1 сая төгрөг баталсан байна. Үүнд ОНХНС-ийн орлогын шилжүүлгээр 503,483.6 сая төгрөг, оны эхний үлдэгдлээс 102,326.5 сая төгрөг бүрдүүлж, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4⁸, 60.2.5⁹, 60.2.8¹⁰, 60.2.9¹¹ дахь заалтуудын дагуу 144,732.9 сая төгрөгийн эх үүсвэрийг нэмж төлөвлөсөн байна.

Хүснэгт №4: ОНХС-ийн эх үүсвэр

(сая төгрөг)

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Эзлэх хувь
1	ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлэг	477,661.2	63.6
2	Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ	25,822.4	3.4
3	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлийг ИТХ-аас баталсан (СЯ-ны э-тайлангаас урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх дүнгээр авсан)	102,326.5	13.6
4	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр	16,974.7	2.3
5	Дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг	82,825.2	11.0
6	Малын тоо толгойн татварын орлого	27,495.6	3.7
7	Бусад орлого	17,437.4	2.3
ДҮН		750,543.1	100.0

Эх сурвалж: АНТАГ-ын аудитын нэгдсэн судалгаа (Дэлгэрэнгүйг судалгаа 1-ээс харна уу)

⁷ 60.2. Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

⁸ татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

⁹ тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

¹⁰ малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

¹¹ Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж

Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн нэмж төлөвлөсөн орлогын эх үүсвэрээс 91,025.5 сая төгрөг төвлөрч, гүйцэтгэл 62.9 хувьтай гарсныг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5: Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-д нэмж төлөвлөсөн эх үүсвэр

(сая төгрөг)

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь
1	Төсвийн тухай хуулийн 60.2.4 дахь заалтын хүрээнд Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр	16,974.7	6,755.9	39.8
2	Төсвийн тухай хуулийн 60.2.5 дахь заалт, ЗГ-ын 2023 оны 457-р тогтоолын 2.2.4 дахь заалтын хүрээнд тухайн ОНХ-ийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, ОУБ-ийн төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг	82,825.2	44,969.8	54.3
3	Малын тоо толгойн татварын орлого	27,495.6	20,631.4	75.0
4	Бусад орлого	17,437.4	18,668.4	107.0
ДҮН		144,732.9	91,025.5	62.9

Эх сурвалж: АНТАГ-ын аудитын нэгдсэн судалгаа (Дэлгэрэнгүйг судалгаа 1-ээс харна уу)

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4¹²-т заасан эх үүсвэрийг 16,974.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 6,755.9 сая төгрөг буюу 39.8 хувьтай байна. Үүний ихэнх хувийг Сүхбаатар аймаг 9,490.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 410.0 сая төгрөг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5¹³-т заасан эх үүсвэрийг 82,825.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 44,969.8 сая төгрөг буюу 54.3 хувьтай байна. Хамгийн өндөр дүнгээр төлөвлөсөн аймгуудын гүйцэтгэлийг авч үзвэл Орхон аймаг 55,361.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 25,361.2 сая төгрөг, Ховд аймаг 6,240.0 сая төгрөг төлөвлөж 7,728.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байв.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-т заасны дагуу ОНХС-ийн эх үүсвэрт малын тоо толгойн албан татварын орлогоор аймаг, нийслэл нь 27,495.6 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон боловч 20,631.4 сая төгрөг төвлөрүүлж, улсын хэмжээнд орлого 6,864.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Монгол орны ихэнх нутгаар 2022, 2023 онуудад өвөлжилт хүндэрснээс мал сүрэг олноор хорогдсон, малчдын амьжиргааны түвшинг харгалзан сумдын ИТХ-аас малын тоо толгойд ногдох албан татварыг сумд харилцан адилгүй буюу зарим сумдын малын тоо толгойд ногдуулах албан татварын хэмжээг “0” төгрөгөөр баталсан зэрэг хүчин зүйлээс шалтгаалсан байна.

Цаг, уур орчны шинжилгээний газраас Монгол Улсын 2023-2024 оны бэлчээрийн даацыг тодорхойлсон дүн мэдээгээр нийт нутгийн 50 орчим хувьд бэлчээрийн даац хүрэлцээтэй, 50 гаруй хувьд бэлчээрийн даац хэтэрсэн тухай мэдээлсэн. Өөрөөр хэлбэл нийт нутгийн 13.8 хувь нь бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн, 6.7 хувь нь даац 3-5 дахин хэтэрсэн, 31.0 хувь нь даац 1-3 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна.

¹² татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

¹³ тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

							(сая төгрөг)
№	Аймаг	Сумын тоо	2023 оны жилийн гүйцэтгэлийн дундаж	Урамшуулал авсан сумын тоо	Урамшуулал авсан сумын эзлэх хувь	Гүйцэтгэлийн урамшуулал авсан дүн	Урамшуулал аваагүй сумын тоо
1	Архангай	19	63.5	8	42.1	554.8	11
2	Баян-Өлгий	13	54.6	3	23.0	235.2	10
3	Баянхонгор	20	67.2	11	55.0	1,028.2	9
4	Булган	16	67.2	9	56.2	658.9	7
5	Говь-Алтай	18	56.0	1	5.5	92.9	17
6	Дорноговь	14	72.2	11	78.5	2,444.7	3
7	Дорнод	14	72.5	13	92.8	2,133.7	1
8	Дундговь	15	79.5	12	80.0	972.3	3
9	Завхан	24	62.2	10	41.6	562.4	14
10	Өвөрхангай	19	77.2	15	78.9	1,075.6	4
11	Өмнөговь	15	71.4	8	53.3	1,165.1	7
12	Сүхбаатар	13	83.7	13	100.0	2,096.0	0
13	Сэлэнгэ	17	75.5	13	76.4	1,932.8	4
14	Төв	27	84.6	24	88.8	2,218.7	3
15	Увс	19	57.7	6	31.5	365.6	13
16	Ховд	17	65.8	12	70.5	1,807.4	5
17	Хөвсгөл	23	70.8	15	65.2	937.0	8
18	Хэнтий	18	82.6	16	88.8	1,279.4	2
19	Дархан-Уул	4	83.7	4	100.0	1,671.1	0
20	Орхон	2	88.0	2	100.0	1,947.5	0
21	Говьсүмбэр	3	88.0	3	100.0	642.7	0
Дүн		330	72.6	209	63.3	25,822.4	121

14

ОНХС-ийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 90 хувиас дээш үнэлэгдсэн сумдад 30 хувь, 70-89 хувиар үнэлэгдсэн сумдад 25 хувийн урамшуулал олгохоор тооцсон бөгөөд 2023 оны үнэлгээний дунджаар Сүхбаатар, Төв, Хэнтий, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгууд 82.7-88.0 хувиар үнэлэгдсэн байна.

Архангай аймгийн Өгийнуур сум 96.0 хувь, Сүхбаатар аймгийн Халзан сум 96.0 хувь, Хэнтий аймгийн Баянхутаг сум 96 хувь, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум 95.0 хувийн үнэлгээг авсан сайн үзүүлэлттэй байсан бол Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Архангай аймгийн Их тамир сумдууд 25 хувь, Архангай аймгийн Хотонт сум 24 хувь, Увс аймгийн Бөхмөрөн сум 23 хувиар үнэлүүлж, хамгийн бага үнэлгээ авсан байна.

Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Төв аймгууд 2024 онд хамгийн өндөр дүнгээр урамшууллыг авч ОНХС-ийн эх үүсвэрээ нэмэгдүүлжээ. Жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр Сүхбаатар, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгуудын бүх сумд урамшуулал авахаар үйл ажиллагаагаа үнэлүүлж чадсан бол Баян-Өлгий аймаг 13 сумаас 3 сум, Говь-Алтай аймаг 18 сумаас 1 сум урамшуулал авах болзлыг хангажээ.

Зарим аймаг болон нийслэл сум, дүүргүүд нэмж төлөвлөсөн ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд санаачилгатай ажиллаагүйгээс орлого тасарсан байна.

Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлттэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн Эрдэнэбулган сум нь МТТАТ-ын төлөвлөсөн дүнгээс 33.4 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлого дансанд төвлөрүүлсэн, мөн зарим сумдууд ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн өвс, тэжээлийн 34.5 сая төгрөгийн орлогыг ЗДТГ-ын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн, мөн сумдын төсвийн орлогын дансанд төвлөрсөн МТТАТ-ын 959.8 сая төгрөгийн орлогыг ОНХС-ийн дансанд дутуу тайлагнасан байна.
- ✓ Баян-Өлгий аймгийн Алтай, Алтанцөгц, Өлгий сум, Цагааннуур тосгон малын тоо, толгойн албан татварын орлогыг сумын ИТХ-аар төлөвлөж, батлуулаагүй, Баяннуур, Булган сумд ногдуулбал зохих МТТАТ -аас илүү төлөвлөсөн бол Бугат, Сагсай, Улаанхус, Дэлүүн, Ногооннуур, Толбо, Цэнгэл сумдууд дутуу төлөвлөсөн байна.
- ✓ Говь-Алтай аймгийн Дарви, Дэлгэр, Тонхил, Халиун, Шарга, Эрдэнэ сумдын ИТХ ОНХС-ийн нийт эх үүсвэрийг 379.5 сая төгрөгөөр зөрүүтэй баталсан, мөн Алтай, Бигэр, Халиун, Чандмань, Эрдэнэ сумдын МТТАТ-ын орлого нийт 132.7 сая төгрөгөөр тасарсан, Бугат, Дэлгэр сумд МТТАТ-ын орлогыг огт төлөвлөөгүй байна. Баян-Уул сум 12.9 сая төгрөг, Цогт сум 7.4 сая төгрөг, Тайшир сум 6.3 сая төгрөг, Дэлгэр сум 4.9 сая төгрөг, Жаргалан сум 4.2 сая төгрөг, Дарви сум 2.2 сая төгрөг, Чандмань сум 0.8 сая төгрөг, нийт 38.9 сая төгрөгийн өвс тэжээлийн үнийг ОНХС-д төвлөрүүлээгүй.
- ✓ Дорнод аймаг нь сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 1,306.8 сая төгрөгийг батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу олгосон.
- ✓ Дорноговь аймгийн Сайхандулаан сумын ИТХ-аар ОНХС-ийн төсвийг 48.9 сая төгрөгөөр, Даланжаргалан, Иххэт сумд ОНХС-ийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг 402.5 сая төгрөгөөр тус тус илүү баталсан. Аймгийн ОНХС-ийн өмнө оны үлдэгдлээс санхүүжих 1,639.6 сая төгрөгийн ТАХ-ны санхүүжилтийн төсвийг батлахдаа үйл ажиллагааны орлогоор санхүүжихээр баталсан байна.
- ✓ Өмнөговь аймгийн Манлай, Ханхонгор, Цогт-Овоо, Цогтцэций сумд ИТХ-ын тогтоолоор уул уурхайн компаниудаас 1,140.4 сая төгрөгийн хандив авахаар төлөвлөсөн, малын тоо толгойн албан татварыг 12 сумд 10.0-183.0 сая төгрөгийн хооронд төлөвлөж Баян-Овоо, Булган, Номгон сумд тус тус төлөвлөөгүй байна. Харин Ханхонгор, Цогтцэций сумд малын тоо толгойн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлээгүйгээс 6 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

- ✓ Сэлэнгэ аймгийн Ерөө, Цагааннуур, Шаамар сумд МТТАТ-ыг 44.8 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн, Баруунбүрэн, Жавхлант, Хүдэр сумдын ИТХ ОНХС-аас санхүүжүүлэх эх үүсвэрийг 73.1 сая төгрөгөөр дутуу төлөвлөж баталсан, Жавхлант сум гүйцэтгэлийг 1.2 сая төгрөгөөр дутуу тайлагнаснаас Сангийн яамны Э-Тайлангийн дүнтэй зөрсөн.
- ✓ Орхон аймгийн Баян-Өндөр сум МТТАТ-ыг 7.6 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч ОНХС-ийн эх үүсвэрт оруулж батлаагүй, малын тоо толгойн албан татвараар 2024 онд 19.5 сая төгрөг бүрдүүлснийг сумын ОНХС-д төвлөрүүлээгүй, мөн Жаргалант сум МТТАТ-аар 2024 онд 38.1 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөнөөс давсан 0.8 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй байна.
- ✓ Завхан аймгийн Алдархаан, Завханмандал сумд ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан 8.2 сая төгрөгийн өвс тэжээлийг малчдад борлуулж, орлогыг санд буцаан төвлөрүүлээгүй.
- ✓ Дундговь аймгийн Говь-Угтаал, Эрдэнэдалай, Өлзийт сумд аймгийн ИТХ-аас баталсан ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 15.0 сая төгрөгөөр алдаатай баталсан. Харин Цагаандэлгэр сум аймгаас олгох орлогын шилжүүлгийг 80.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгол хийгдсэн байхад сумын ИТХ нь эх үүсвэрийг нэмж батлаагүй байна.
- ✓ Дундговь аймгийн ОНХС болон Баянжаргалан, Дэлгэрцогт сумд ОНХС-г дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламж, орлогыг 865.0 сая төгрөгөөр төлөвлөж баталсан бол бусад сумд тус орлогын эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.
- ✓ Өвөрхангай аймгийг 19 сум 1,376.6 сая төгрөгийн МТТАТ-н орлогын авлага үүссэн, Бүрд, Баян-Өндөр, Баянгол, Гучин-Ус, Өлзийт, Тарагт, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хужирт сумд МТТАТ-н орлогыг төлөвлөж батлуулахдаа өмнөх оны авлага /өмнөх оны татварын үлдэгдлээс санхүүжих/, тайлант оны албан татвараас санхүүжих дүнг салгаж тусгаагүй байна.
- ✓ Төв аймгийн Алтанбулаг, Батсүмбэр, Баян, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцагаан, Зуунмод, Лүн сумд малын тоо толгойн албан татварын дансанд төвлөрсөн 272.2 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй.
- ✓ Хөвсгөл аймгийн ОНХС-ын орлогын эх үүсвэрийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар 748.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосныг батлуулаагүй, МТТАТ-ын орлогын эх үүсвэрийг үндэслэлтэй тооцоолоогүйгээс 528.4 сая төгрөгөөр дутуу батлуулсан, өмнөх жилийн МТТАТ-ын давсан орлого 29.1 сая төгрөгийг тайлант онд эх үүсвэр болгоогүйгээр батлуулсан. Мөн аймгийн ОНХС-д МТТАТ-аас бүрдүүлэх орлогын эх үүсвэрт Баянзүрх сум 15.0 сая төгрөгөөр, Галт сум 0.3 сая төгрөгөөр нийт 15.3 сая төгрөгөөр бүрэн төвлөрүүлээгүй байна.
- ✓ Хэнтий аймаг нийгмийн хариуцлагын хүрээнд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч 59 аж ахуйн нэгж хамтран ажиллах 932.0 сая төгрөгийн гэрээ байгуулснаас аймгийн ОНХС-ийн дансанд 9 аж ахуйн нэгж 302.5 сая төгрөг, Дархан сумын ОНХС-д 49.9 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Гэрээнд заасан 932.0 сая төгрөгийн 610.0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн “Нэр заагдаагүй бусад орлого” дансанд 48 ААН, 322.0 сая төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт дансанд 11 ААН шилжүүлэхээр заажээ.
- ✓ Хэнтий аймаг ОНХС-ийн эх үүсвэрийг татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болсон нэмэгдлийг төлөвлөж, бүрдүүлээгүй, аймаг, сумын ИТХ-аар өмнөх он үлдэгдлийг 722.6 сая төгрөгөөр дутуу баталсан, Батширээт, Баян-Адарга, Баян-Овоо, Дадал, Норовлин, Цэнхэрмандал сумаас бусад 17 сум, тосгон нь МТТАТ-ыг бүрэн чөлөөлсөн байна. Мөн Биндэр сумын орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрсөн МТТАТ-ын 34.1 сая төгрөгийн орлогыг ОНХС-ын дансанд төвлөрүүлээгүй.
- ✓ Ховд аймгийн Дуут сумын данс андуурсан 6.4 сая төгрөгийн гүйлгээг Сангийн яамны Э-тайланд тусгасан.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас нийт 5,994.6 сая төгрөгийн дээрх зөрчилд 73.0 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 1,300.6 сая төгрөгийн 19 албан шаардлага, 4,620.9 сая төгрөгийн 31 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

Говь-Алтай аймгийн санал:

Нэгтгэсэн
тайланд
тусгуулах
санал

Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5.9-д заасны дагуу ОНХС-аас тэжээлийн нөөц бүрдүүлж, буцаан иргэдэд үнэ төлбөргүй, зээлээр, хөнгөлөлттэй үнээр олгож байгаа нь Төсвийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 болон дээрх журмын 4.7.6-д заасантай нийцэхгүй байгаа тул журамд өөрчлөлт оруулах саналтай байна.

1.2. Иргэдийн саналаар дэмжигдээгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг зөрчил давтагдсаар байна

1.2.1 Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч нар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлэх талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1¹⁵, 63.2¹⁶, 63.3¹⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 5¹⁸, 6¹⁹, 7²⁰ дугаар зүйлд тус тус заасан байна.

Шат шатны төсвийн захирагчид журамд заасны дагуу 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал асуулгыг иргэд, олон нийтээс цахимаар болон бүлгийн ярилцлагаар, саналын хуудсаар явуулж, давхардсан тоогоор 2,341,082 иргэнээс санал авчээ.

Хүснэгт №7: Иргэдийн санал өгсөн байдал

№	Саналын тоо	2023 он	2024 он	Зөрүү
1	Цахим	144,483	421,617	277,134
2	Бүлгийн ярилцлага	137,862	161,883	24,021
3	Цаасаар	1,798,022	1,757,582	(40,440)
Нийт дүн		2,080,367	2,341,082	260,715

Эх сурвалж: АНТАГ-ын аудитын нэгдсэн судалгаа (Дэлгэрэнгүйг судалгаа 10-аас харна уу)

Дээрх судалгаанаас харахад ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэд олон нийтээс цаасан хэлбэрээр өгсөн саналын тоо өмнөх оноос 40,440 саналаар буурсан бол цахимаар өгсөн саналын тоо 277,134 саналаар буюу 2.9 дахин өссөн байна.

Энэ нь сүүлийн жилүүдэд ОНХС-ийн гар утасны аппликейшн, ОНХНС, УМС, Төрийн үйлчилгээний Е-Монголиа нэгдсэн систем болон Е-Монголиа аппликейшн зэрэг цахим сүлжээг үе шаттай хэрэгжүүлснээр санал өгсөн иргэдийн тоо нэмэгдсэн байна.

Иргэд өмнөх оноос 1.5 дахин их буюу 24,752 ТАХ-ний санал өгснөөс 14,949 санал батлагдаж, 9,928 санал цуцлагдсан байна. (Дэлгэрэнгүйг судалгаа 10-аас харна уу)

Аймгуудын ОНХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн санал өгсөн байдлыг сонгуулийн насны хүн амын тоотой харьцуулахад Архангай аймаг нийт сонгуулийн насны иргэдийн 30.8 хувь, Дархан-Уул аймаг 16.1 хувь, Дорноговь аймаг 17.3 хувь, Орхон аймаг 20.7 хувь, Төв аймаг 15.7 хувь, Увс аймаг 22.7 хувь, Хэнтий аймаг 37.6 хувь нь хамрагджээ. Энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй, иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг, идэвх оролцоо сул байгаатай холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгод хүрэхийн тулд ТАХ-ний төлөвлөлтөд цахимаар санал өгөх боломжийг иргэдэд сурталчлан таниулж,

¹⁵ Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

¹⁶ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

¹⁷ Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ

¹⁸ Тав. Баг, хорооны түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх

¹⁹ Зургаа. Сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх


²⁰ Долоо. Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн төлөвлөх

техник технологийн дэвшлийг ашиглан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломж байгааг дээрх судалгаа харуулж байна.

Аудитын явцад 21 аймаг, нийслэлийн нийт 18,789 иргэнээс googleform ашиглан 9 асуумжаар санал асуулга авч нэгтгэснийг дүрслэл 3, 4-өөр харуулав.

Дүрслэл №3:


2. Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд саналаа өгсөн үү?
18,596 хариулт



санал өгдөг гэж хариулсан байна.

Дүрслэл №4:

3. 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг та ямар хэлбэрээр өгсөн бэ?
18,788 хариулт



Та 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-д саналаа өгсөн үү? гэсэн асуулгад 67.8 хувь нь “Тийм”, 32.2 хувь нь “Үгүй” гэж хариулсан бөгөөд саналаа өгсөн иргэдийн 36.2 хувь нь Багийн иргэдийн нийтийн хурлаас, 25.7 хувь нь гар утасны аппликейшнаас мэдээлэл авч,

Дээрх санал асуулгаас иргэдийн ТАХ-нд санал өгөөгүй 32.2 хувь нь ОНХС-ийн талаарх мэдлэг, мэдээлэл хангалттай биш, нөгөө талаас хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, мэдээлэл түгээх байдал хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитаар ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3²¹ дахь заалт, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.3.2²² заалтуудтай нийцсэн эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрчээ.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг: Иргэдийн саналаар дэмжигдээгүй 1,939.1 сая төгрөгийн 82 ТАХ-г аймаг, сумын ИТХ-аар батлуулсан.
- ✓ Баянхонгор аймаг: Шинэжинст сумын ИТХ-ын тогтоолоор 2,115.3 сая төгрөгийн 14 арга хэмжээг батлахдаа ИНХ-ын дарга болон бусад холбогдох албан хаагчид албан тушаалын байдлаа урвуулан ашигласан байж болзошгүй гэж үзэн хуулийн байгууллагад шилжүүлсэн.
- ✓ Баян-Өлгий аймаг: Аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн 370.4 сая төгрөгийн 23 ТАХ, Буянт сум 80.5 сая төгрөгийн 15 ТАХ, Өлгий сум 255.4 сая төгрөгийн 30 ТАХ, Цэнгэл сум 210.0 сая төгрөгийн 12 ТАХ, Ногооннуур сум 106.4 сая төгрөгийн 54 ТАХ иргэдийн саналгүй, эрэмбэлэгдээгүй.
- ✓ Говь-Алтай аймаг: Иргэдийн саналаар дэмжигдээгүй байхад аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 5,395.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 ТАХ, Алтай, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Цээл, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сум 4,475.2 сая төгрөгийн 126 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.
- ✓ Говьсүмбэр аймаг: Сумдын ИТХ-аар иргэдийн саналаар дэмжигдээгүй 1,170.3 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээг баталсан.
- ✓ Дархан-Уул аймаг: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналд Дархан, Орхон сумын иргэдийн 10.9-13.4 хувийг буюу маш бага иргэдийг хамруулсан байна
- ✓ Дорноговь аймаг: Иргэдийн саналаар дэмжигдээгүй Даланжаргалан сум 446.7 сая төгрөгийн 4 ТАХ, Мандах сум 529.2 сая төгрөгийн 6 ТАХ, Хатанбулаг сум 703.1 сая төгрөгийн 6 ТАХ, Хөвсгөл сум 456.9 сая төгрөгийн 4 ТАХ-г тус тус сумын ИТХ-аар баталсан.

²¹ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно

²² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

- ✓ Завхан аймаг: Баянхайрхан, Ургамал сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс авах саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, олон нийтийн оролцоог бүрэн хангаж ажиллаагүй.
- ✓ Орхон аймаг: Баян-Өндөр сумын ИТХ-аар иргэдийн саналаар дэмжигдээгүй 5,308.2 сая төгрөгийн 90 ТАХ-г баталсан.
- ✓ Өвөрхангай аймаг: Иргэдийн саналд тусгагдаагүй аймгийн ОНХС-аар 639.3 сая төгрөгийн 4 ТАХ, Хужирт сум 37.1 сая төгрөгийн 1 ТАХ-г баталсан. Арвайхээр сумын багуудын ирц хангалтгүй байхад ТАХ-г хэлэлцэн, эрэмбэлж баталсан, ач холбогдлоор тэргүүнд эрэмбэлэгдээгүй 250.0 сая төгрөгийн 2 ТАХ-г баталсан
- ✓ Өмнөговь аймаг: Иргэдээс санал авч эрэмбэлээгүй Номгон сум 1,173.4 сая төгрөгийн 21 ТАХ, Ханхонгор сум 354.0 сая төгрөгийн 7 ТАХ, Цогт-Овоо сум 680.3 сая төгрөгийн 9 ТАХ, Ноён сум 380.7 сая төгрөгийн 7 ТАХ-г тус тус сумын ИТХ-аар баталсан байна. Баян-овоо, Даланзадгад, Манлай, Ханбогд, Ханхонгор, Цогтцэций сумдын санал хураалтын ирц хангалтгүй байхад баталсан.
- ✓ Сүхбаатар аймаг: Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумдын ИТХ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим ТАХ-ний жагсаалтыг иргэдийн санал, оролцоогүйгээр баталжээ. Мөн аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийн хүрээнд иргэд олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй.
- ✓ Сэлэнгэ аймаг: Сайхан сум иргэдийн санал авч, эрэмбэлэгдээгүй 262.9 сая төгрөгийн 4 ТАХ-г баталсан. Зүүнбүрэн, Цагааннуур, Орхон, Шаамар зэрэг сумд хурлын ирцийг бүрэн бүрдүүлээгүй, ирцийг гарын үсгээр баталгаажуулаагүй.
- ✓ Төв аймаг: Эрдэнэ сум 89.3 сая төгрөгийн 1 ТАХ, Баянжаргалан сум 259.0 сая төгрөгийн 4 ТАХ, Баянхангай сум 81.5 сая төгрөгийн 4 ТАХ, Баян сум 17.4 сая төгрөгийн 1 ТАХ-г иргэдийн саналаар дэмжигдээгүй байхад ТАХ-г сумын ИТХ-аар батлуулсан байна.
- ✓ Увс аймаг: Өлгий сумын 19.3 сая төгрөгийн 4 ТАХ, Малчин сумын 215.5 сая төгрөгийн 25 ТАХ нь иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй.
- ✓ Ховд аймаг: Мянгад, Мөнххайрхан, Цэцэг сумдад ОНХС-ийн 2024 оны хөрөнгө оруулалтын зарим ажлыг иргэдээс санал авч эрэмбэлээгүй, нэгдсэн жагсаалт гаргаагүй, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээг эдийн засаг нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаж байгаа эсэхийг үнэлээгүй.
- ✓ Хөвсгөл аймаг: Иргэдийн саналаар дэмжигдээгүй байхад аймгийн ОНХС 4,884.3 сая төгрөгийн 39 ТАХ, Мөрөн сум 676.3 сая төгрөгийн 5 ТАХ, Бүрэнтогтох сум 421.4 сая төгрөгийн 18 ТАХ, Цэцэрлэг сум 463.4 сая төгрөгийн 8 ТАХ-г ИТХ-аар батлуулсан байна.
- ✓ Хэнтий аймаг: Өмнөдэлгэр сум 291.2 сая төгрөгийн 5 ТАХ, Баян-Адарга сум 112.2 сая төгрөгийн 3 ТАХ, Норовлин сум 34.2 сая төгрөгийн 2 ТАХ, Дадал сум 75.6 сая төгрөгийн 2 ТАХ, Жаргалтхаан сум 50.0 сая төгрөгийн 2 ТАХ, Галшар сум 100.0 сая төгрөгийн 1 ТАХ-г сумын ИТХ-аар баталж, хэрэгжүүлсэн байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас нийт 10,565.6 сая төгрөгийн дээрх зөрчилд 10,495.6 сая төгрөгийн 37 албан шаардлага, 70.0 сая төгрөгийн 36 зөвлөмжийг шалгадагч байгууллагуудад хүргүүлж, 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Аудитаар аймаг, нийслэлд илэрсэн зөрчлийг нэгтгэхэд 18 аймагт иргэдийн саналгүй 33,045.2 сая төгрөгийн 696 төсөл арга хэмжээг төлөвлөсөн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 14.5 хувиар буюу 4,132.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн төлөвлөлтөд саналыг хүртээмжтэй байдлаар аваагүй, иргэдээс санал авч эрэмбэлээгүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн зөрчил бүрэн арилахгүй давтагдсаар байгаа нь иргэдийн оролцоонд тулгуурлан орон нутгийн хөгжлийн асуудлыг тодорхойлох, хөрөнгө оруулалтын шийдвэрийг хамтран гаргах үндсэн зарчим алдагдсан байна.

1.2.2 Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9²³, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2²⁴, 63.3²⁵, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1²⁶, 4.1.3²⁷-т ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г аймаг, нийслэл, сум, дүүргийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулж төлөвлөхийг хуульчилжээ.

Улсын хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 10,942 төсөл, арга хэмжээний 10,566 буюу 96.5 хувь нь аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан бол 376 буюу 3.5 хувь нь уялдаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг: Батцэнгэл сум 29.0 сая төгрөгийн 2, Өлзийт сум 92.2 сая төгрөгийн 5, Эрдэнэмандал сум 9.0 сая төгрөгийн 3, Төвшрүүлэх сум 18.0 сая төгрөгийн 1, Өндөр-Улаан сум 52.3 сая төгрөгийн 4, Тариат сум 179.2 сая төгрөгийн 5, Эрдэнэбулган сум 140.7 сая төгрөгийн 4, Жаргалант сум 109.0 сая төгрөгийн 10, нийт 629.4 сая төгрөгийн 34 ТАХ сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй.
- ✓ Баян-Өлгий аймаг: Аймгийн болон сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулж, аймгийн орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хөрөнгө оруулалтын ажил хийгээгүй байна.
- ✓ Говь-алтай аймаг: Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан 4 ТАХ нь аймгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй байна. Баян-Уул, Бугат, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга, Есөнбулаг сумын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд тусгаагүй 92 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.
- ✓ Дундговь аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 9 төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулаагүй.
- ✓ Өмнөговь аймаг: Манлай сумын 4 ТАХ, Цогт-Овоо сумын 6 ТАХ, Цогтцэций сумын 1 ТАХ, Ханхонгор сумын 3 ТАХ нь сумын 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй.
- ✓ Увс аймаг: Сумын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт уялдаагүй нийт 31 төсөл, арга хэмжээг Наранбулаг, Малчин, Бөхмөрөн сум иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан.
- ✓ Хэнтий аймаг: Батноров сумын 475.0 сая төгрөгийн 8, Баян-Адарга сумын 88.0 сая төгрөгийн 4, Баянмөнх сумын 33.3 сая төгрөгийн 3, Баян-Овоо сумын 215.2 сая төгрөгийн 5, Баянхутаг сумын 397.0 сая төгрөгийн 9, Дадал сумын 155.0 сая төгрөгийн 3, Жаргалтхаан сумын, 33.4 сая төгрөгийн 4, Мөрөн сумын 260.3 сая төгрөгийн 5, Өмнөдэлгэр сумын 568.0 сая төгрөгийн 10, Хэрлэн сумын 1,123.7 сая төгрөгийн 9 ТАХ нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 10,381.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 6,887.3 сая төгрөгийн 11 албан шаардлага, 3,494.0 сая төгрөгийн 18 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд нийт зөрчил өмнөх оноос 16.5 дахин өсжээ.

23 Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

24 Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

25 Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагчийн ажлын алба ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөлд өргөн мэдүүлнэ.

22 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

27 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх;

1.2.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²⁸, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3²⁹-т заасан үндсэн нөхцөлийг хангасан байх зохицуулалттай.

Аудитаар дээрх хууль, журамд заасан шаардлага, шалгуурыг хангаагүй дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 579.5 сая төгрөгийн 3 ТАХ нь төсөв тооцоолол хийгдээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.
- ✓ Баянхонгор аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 1,280.0 сая төгрөгийн 5 ТАХ, Баянговь сум 1 ТАХ, Баянлиг сум 221.3 сая төгрөгийн 2 ТАХ нь зураг төсөвгүй, техникийн тодорхойлолт бүрэн хийгдээгүй, үндэслэлгүй боловсруулсан
- ✓ Баян-Өлгий аймаг: Төсвийн тухай хуулийн шаардлага хангаагүй Ногоон нуур сум 102.1 сая төгрөгийн 15 ТАХ, Бугат сум 21.8 сая төгрөгийн 2 ТАХ, Улаанхус сум 18.0 сая төгрөгийн 1 ТАХ-г төлөвлөж, батлуулсан.
- ✓ Говь-Алтай аймаг: Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх ТАХ-г техник эдийн засгийн үндэслэл, ажлын даалгавар, зураг төсөвгүй Алтай сум 902.9 сая төгрөгийн 16, Баян-Уул сум 105.8 сая төгрөгийн 6, Бигэр сум 775.1 сая төгрөгийн 48, Бугат сум 449.8 сая төгрөгийн 14, Дарив сум 264.8 сая төгрөгийн 21, Дэлгэр сум 463.6 сая төгрөгийн 13, Жаргалан сум 252.8 сая төгрөгийн 14, Тайшир сум 243.0 сая төгрөгийн 17, Тонхил сум 574.4 сая төгрөгийн 28, Төгрөг сум 575.8 сая төгрөгийн 30, Халиун сум 499.9 сая төгрөгийн 61, Хөхморьт сум 313.2 сая төгрөгийн 20, Цогт сум 908.4 сая төгрөгийн 25, Цээл сум 789.2 сая төгрөгийн 23, Чандмана сум 450.3 сая төгрөгийн 29, Шарга сум 330.6 сая төгрөгийн 17, Эрдэнэ сум 744.0 сая төгрөгийн 26, Есөнбулаг сум 2,406.5 сая төгрөгийн 16 ТАХ-г сумдын ИТХ-ын тогтоолоор баталсан.
- ✓ Говьсүмбэр аймаг: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үндэсний их баяр наадмын арга хэмжээний зардлыг Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын дагуу төлөвлөөгүй, 4-42 дахин нэмэгдүүлэн төлөвлөж, батлуулсан. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсвийн тооцоолол дутуу, урьдчилсан судалгаа хийгдээгүй 2,275.3 сая төгрөгийн 8 ТАХ-г аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор батлуулсан.
- ✓ Дархан-Уул аймаг: Дархан сумын ОНХС 236.5 сая төгрөгийн 2 ТАХ, Шарын гол сум 211.6 сая төгрөгийн 8 ТАХ-г иргэдийн санал аваагүй, Хонгор сум 400.0 сая төгрөгийн 2 ТАХ-ний зураг төсөв эцэслэн гараагүй байхад ИТХ-аар баталсан. Шарын гол сумын ОНХС-ийн шилжих хөрөнгө оруулалтын төсвөөс 27.0 сая төгрөгийн 2 ТАХ-шинээр хэрэгжүүлэхээр баталсан.
- ✓ Дорноговь аймаг: Даланжаргалан сум 49.9 сая төгрөгийн 1, Иххэт сум 186.6 сая төгрөгийн 1, Сайншанд сум 470.0 сая төгрөгийн 2 ТАХ техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв батлуулаагүй.
- ✓ Дундговь аймаг: Зураг төсөвгүй, эдийн засгийн тооцоо судалгаагүй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдээгүй Адаацаг сум 221.0 сая төгрөгийн 9, Сайхан-Овоо сум 296.9 сая төгрөгийн 12, Хулд сум 153.4 сая төгрөгийн 8, Өлзийт сум 206.0 сая төгрөгийн 6, Цагаандэлгэр сум 245.9 сая төгрөгийн 10 ТАХ-г жагсаалтад оруулж баталсан.
- ✓ Завхан аймаг: Ургамал, Баянхайрхан сумдын шат, шатны төсөв захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн санал авч эрэмбэлээгүй, урьдчилсан жагсаалтад тусгагдаагүй, техник эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг батлуулсан.
- ✓ Орхон аймаг: Зураг, төсөв нь хийгдээгүй 42 ТАХ-нд 26,242.0 сая төгрөг төлөвлөж баталсан.
- ✓ Өмнөговь аймаг: Аймгийн ОНХС-ийн 2,201.7 сая төгрөгийн 8, Баян-Овоо сумын 155.0 сая төгрөгийн 3, Манлай сумын 1,084.7 сая төгрөгийн 5, Гурван тэс сумын 549.2 сая төгрөгийн 4,

²⁸ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

²⁹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх

Сэврэй сумын 64.1 сая төгрөгийн 4 ТАХ нь зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, магадлалын дүгнэлт гараагүй, багийн ИНХ-аас гарсан саналаас зөрүүтэй, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 8 дугаар хавсралт маягтын дагуу батлаагүй. Ханбогд сумын ИТХ-аар ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх ТАХ-г батлахдаа ТАХ-г эрэмбэлж, жагсаагаагүй, багийн ИНХ-аар төслийн шаардлагатай таамагт төсөвт өртгийг тодорхойлж танилцуулаагүй.

- ✓ Сүхбаатар аймаг: Зураг төсөл нь хийгдээгүй 7,719.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 27 ТАХ-г аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөснөөс шалтгаалж худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 7,261.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 ТАХ огт хэрэгжээгүй.
- ✓ Сэлэнгэ аймаг: Зураг, төсөв, тооцоо судалгаагүй аймаг, сумдын ОНХС-аар 2024 онд хэрэгжүүлэх нийт 4,479.0 сая төгрөгийн 20 ТАХ-г аймаг, сумдын ИТХ-аар баталсан, төсвийн тодотголоор аймгийн ОНХС-ийн 37 ТАХ-ний ХАА-ын үр дүнд бий болсон 302.7 сая төгрөгийн хэмнэлтийг гэрээний дүнгээр бууруулж, 4 ТАХ-ний батлагдсан төсвийг нэмэгдүүлэн төлөвлөж, баталсан, Сайхан сум 1 ТАХ-ний анхны батлагдсан төсвийг тодотголоор бууруулж баталсан.
- ✓ Төв аймаг: Борнуур сумын ИТХ-аар зураг төсөвгүй 295.0 сая төгрөгийн 9 ТАХ-г баталсан, Угтаалцайдам сум 13.0 сая төгрөгийн 1 ТАХ-г төсөв батлах жагсаалтад оруулж батлаагүй.
- ✓ Хөвсгөл аймаг: Иргэдийн саналаар дэмжигдээгүй, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй Аймгийн ОНХС 4,884.3 сая төгрөгийн 39, Мөрөн сум 676.3 сая төгрөгийн 11, Бүрэнтогтох сум 514.4 сая төгрөгийн 20, Цэцэрлэг сум 513.4 сая төгрөгийн 9, Цагаан-Уул сум 315.0 сая төгрөгийн 4 ТАХ-г аймаг, сумдын ИТХ-аар баталсан, Бүрэнтогтох сумын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 35.0 сая төгрөгийн 1 ТАХ-г 2024 оны шилжих хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж батлаагүй.
- ✓ Хэнтий аймаг: Биндэр сум 29.8 сая төгрөгийн 1 ТАХ-г сумын ИТХ-аар батлуулаагүй, зарцуулсан, Галшар сум 2, Батноров сум 1 ТАХ-ний зураг, төсөвт магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулаагүй, Жаргалтхаан сум 163.8 сая төгрөгийн 11 ТАХ-ний ажлын даалгавар, техникийн тодорхойлолт байхгүй байхад сумдын ИТХ-аар баталсан.
- ✓ Нийслэл: Нийслэл, дүүргийн ОНХС-аар нийт нэр, байршил тодорхой бус 35,803.2 сая төгрөгийн 117 ТАХ, зураг төсөвгүй 17,725.1 сая төгрөгийн 104 ТАХ-г ИТХ-аар баталсан.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 32,610.1 сая төгрөгийн зөрчилд 28,438.2 сая төгрөгийн 39 албан шаардлага, 4,171.9 сая төгрөгийн 21 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

Төсвийн тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл арга хэмжээг тусгахгүй байгаа зөрчил өмнөх онтой харьцуулахад 44.9 хувиар өссөн байна. Энэ нь төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулах, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

1.2.4 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2³⁰-т аймаг, нийслэлийн түвшинд, 4.4³¹, 4.5³²-т сум, дүүргийн түвшинд хамаарах чиг үүргийг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тус тус заажээ.

Улсын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 750,460.0 сая төгрөгийн 10,942 ТАХ-г хэрэгжүүлэхээр аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аар баталж, гүйцэтгэлээр 8,998 төсөл, арга хэмжээнд 523,461.3 сая төгрөг зарцуулсан байна.

³⁰ Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

³¹ Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

³² Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ

ОНХС-аар 2024 онд хэрэгжүүлсэн 8,998 ТАХ-ний 1,281 ТАХ буюу 14.2 хувийг аймаг, нийслэлийн түвшинд, 7,717 ТАХ буюу 85.8 хувийг сум, дүүргийн түвшинд хэрэгжүүлжээ.

Аймаг, нийслэлийн түвшинд зарцуулсан нийт 233,285.9 сая төгрөгийн 1,281 ТАХ-г журамд заасан чиг үүргээр ангилж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл №5: Аймаг, нийслэлийн чиг үүрэг хувиар:



“Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи” чиг үүргийн хүрээнд 67,274.3 сая төгрөгийн 425 ТАХ;

“Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ” чиг үүргийн хүрээнд 97,462.8 сая төгрөгийн 343 ТАХ;

“Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах” чиг үүргийн хүрээнд 37,308.9 сая төгрөгийн 245 ТАХ;

“Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах” чиг үүргийн хүрээнд 5,074.8 сая төгрөгийн 91 ТАХ;

“Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах” чиг үүргийн хүрээнд 5,256.0 сая төгрөгийн 46 ТАХ;

“Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх” чиг үүргийн хүрээнд 5,034.3 сая төгрөгийн 46 ТАХ;


“Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт” чиг үүргийн хүрээнд 964.3 сая төгрөгийн 8 ТАХ;

“Ажлын байр бий болгох” чиг үүргийн хүрээнд 1,955.0 сая төгрөгийн 11 ТАХ;

Харин журамд заасан чиг үүрэгт хамааралгүй 12,955.4 сая төгрөгийн 66 ТАХ байна. ТАХ-ний жагсаалтын (Дэлгэрэнгүйг [хавсралт №-1.2.4А-өөс харна уу](#))

Мөн сум, дүүргийн түвшинд зарцуулсан нийт 290,175.5 сая төгрөгийн 7,717 ТАХ-г журамд заасан чиг үүргээр ангилж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл №6: Сум, дүүргийн чиг үүрэг хувиар:



“Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи” чиг үүргийн хүрээнд 53,178.4 сая төгрөгийн 1,789 ТАХ;

“Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ” чиг үүргийн хүрээнд 100,076.3 сая төгрөгийн 1,551 ТАХ;

“Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах” чиг үүргийн хүрээнд 81,310.9 сая төгрөгийн 1,958 ТАХ;

“Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах” чиг үүргийн хүрээнд 5,689.5 сая төгрөгийн 290 ТАХ;

“Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах” чиг үүргийн хүрээнд 10,305.4 сая төгрөгийн 371 ТАХ;

“Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх” чиг үүргийн хүрээнд 1,772.8 сая төгрөгийн 67 ТАХ;

“Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт” чиг үүргийн хүрээнд 206.7 сая төгрөгийн 17 ТАХ;

“МТТАТ-ын орлого”-оос чиг үүргийн хүрээнд 26,651.1 сая төгрөгийн 1,443 ТАХ;

“Ажлын байр бий болгох” чиг үүргийн хүрээнд 5,157.2 сая төгрөгийн 65 ТАХ;

“Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт” чиг үүргийн хүрээнд 1,009.7 сая төгрөгийн 52 ТАХ;

Харин журамд заасан чиг үүрэгт хамааралгүй 4,817.2 сая төгрөгийн 114 ТАХ-ний жагсаалтын (Дэлгэрэнгүйг [хавсралт №1.2.4Б-өөс харна уу](#))

“ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэгт нийцээгүй ТАХ-г хэрэгжүүлсэн дараах зөрчил илэрсэн

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 285.9 сая төгрөгийн “Багийн Засаг дарга нарыг мотоцикл, тоног төхөөрөмжөөр хангах” ТАХ, Жаргалант сумын 27.6 сая төгрөгийн “ЗДТГ-ын төрийн албан хаагчдын 2 айлын барилгад их завсар хийх” ТАХ, Хайрхан сум 50.0 сая төгрөгийн “Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах” ТАХ-ний хүрээнд 30.0 сая төгрөгийн өртөгтэй хөшөө барьсан;
- ✓ Баянхонгор аймаг: Аймгийн ОНХС 582.0 сая төгрөгийн 5 ТАХ, Бууцагаан сум 18.2 сая төгрөгийн 1 ТАХ;
- ✓ Баян-Өлгий аймаг: Аймгийн чиг үүрэгт хамааралгүй 20.0 сая төгрөгийн 1 ТАХ-г батлуулан хэрэгжүүлсэн;
- ✓ Говь-Алтай аймаг: Аймгийн ОНХС-ийн 3,967.4 сая төгрөгийн 7 ТАХ, Сумдын ОНХС-ийн 518.8 сая төгрөгийн 14 ТАХ;
- ✓ Завхан аймаг: Орон нутгийн хөгжлийн сангийн журмын чиг үүрэгт хамааралгүй аймгийн ОНХС 142.4 сая төгрөгийн 6 ТАХ, Алдархаан, Баянтэс, Дөрвөлжин, Тосонцэнгэл, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Улиастай сумд 246.9 сая төгрөгийн 16 ТАХ;
- ✓ Өмнөговь аймаг: Номгон сум 236.0 сая төгрөгийн 2 ТАХ, Баян-Овоо сум 236.6 сая төгрөгийн 3 ТАХ, Манлай сум 99.9 сая төгрөгийн 1 ТАХ, Ханхонгор сум 26.4 сая төгрөгийн 1 ТАХ, Цогт-Овоо сум 27.3 сая төгрөгийн 2 ТАХ;
- ✓ Сэлэнгэ аймаг: Түшиг сумын 56.7 сая төгрөгийн “ЗДТГ-т автомашины граж барих” ТАХ;
- ✓ Хэнтий аймаг: Дадал сум 33.9 сая төгрөгийн 1 ТАХ, Мөрөн сум 73.0 сая төгрөгийн 1 ТАХ, Дархан сум 15.0 сая төгрөгийн 1 ТАХ, Дэлгэрхаан сум 19.5 сая төгрөгийн 1 ТАХ, Цэнхэрмандал сум 5.0 сая төгрөгийн 1 ТАХ;

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 1,280.8 сая төгрөгийн зөрчилд 948.3 сая төгрөгийн 18 албан шаардлага, 332.4 сая төгрөгийн 5 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 68-79 хувийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, дэд бүтцийг сайжруулах, орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах зэрэг ажилд зарцуулсан нь журамд заасан чиг үүргийн хүрээнд иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг хангахад чиглэсэн байна.

Харин 1-1.4 хувийг өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт, ажлын байр бий болгох ТАХ хэрэгжүүлсэн нь хангалтгүй байгаа тул ОНХС-ийн үндсэн

зорилгод нийцсэн эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих, иргэдийн өрхийн орлого, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.



БҮЛЭГ 2: ЗАХИАЛАГЧ ШУУД ХУДАЛДАН АВАХ, ХАРЬЦУУЛАЛТЫН АРГЫГ ХЭРЭГЛЭХ ЗОРИЛГООР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙГ ХУВААХ, ШУУД ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЗӨРЧИЛ БУУРАХГҮЙ ДАВТАГДАЖ БАЙНА

2.1 Холбогдох албан тушаалтнуудын хяналт сул, хариуцлагагүй байдал нь хууль, журам зөрчигдөх, алдаа зөрчил давтагдан гарах, үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлж байна

2.1.1 Улсын хэмжээнд 2024 онд шинээр нийт 641,221.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8,709 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Хүснэгт №8: Худалдан авах ажиллагааны тоо, мэдээ

№	Үзүүлэлт	Төсөл, арга хэмжээ	
		Тоо	Төсөвт өртөг /сая.төг/
1	Нээлттэй тендер шалгаруулалт	1,125	411,512.4
2	Харьцуулалт	1,702	107,390.3
3	Гэрээ шууд байгуулах	2,225	49,453.7
4	Нэг үүсвэрээс худалдан авах	334	5,636.8
5	Олон нийтийн оролцоотой худалдан авалт	111	1,877.4
6	Худалдан авах ажиллагаа зарлаагүй /ШХА-20.0 сая төгрөгөөс доош/	3,212	65,350.5
Нийт дүн		8,709	641,221.1

(Дэлгэрэнгүйг судалгаа 5-аас харна уу)

Нийслэл, зарим аймаг, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон үнэлгээний хороод ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, МУЗГ-ын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2023 оны А/250 тоот тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг тус тус зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн Батцэнгэл сум 40.0 сая төгрөгийн 1, Баян-Өлгийн аймгийн ОНХС 306.4 сая төгрөгийн 3, Бугат, Булган сумууд 89.0 сая төгрөгийн 2, Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөв хийлгэх 200.0 сая төгрөгийн 1, Баянхонгор сум 50.0 сая төгрөгийн 1, Говь-Алтай аймгийн Бугат, Дэлгэр, Халиун, Шарга сумд 167.0 сая төгрөгийн 4, Говьсүмбэр аймгийн Баянтал сум 40 сая төгрөгийн 1, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Төгрөг, Өлзийт сум 128.2 сая төгрөгийн 3, Сэлэнгэ аймгийн Ерөө, Зүүнбүрэн, Цагааннуур сум 194.5 сая төгрөгийн 5, Төв аймгийн Баянхангай, Мөнгөнморьт, Эрдэнэ, Эрдэнэсант сумд 137.8 сая төгрөгийн 4, Ховд аймгийн ОНХС болон Алтай, Жаргалант, Үенч, Цэцэг, Дарви, Мөнххайрхан сум 477.0 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээний төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулсан;
- ✓ Баян-Өлгий аймгийн Толбо сум 80.2 сая төгрөгийн 1, Буянт сум 6.0 сая төгрөгийн 2, Цэнгэл сум 20.0 сая төгрөгийн 1 тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдаж аваагүй;
- ✓ Архангай аймгийн Хайрхан сум 28.0 сая төгрөгийн 1, Баянхонгор аймгийн Шинэжинст сум 70.0 сая төгрөгийн 1, Дархан-Уул аймгийн Орхон сум 85.5 сая төгрөгийн 2, Завхан аймгийн Дөрвөлжин сум 22.9 сая төгрөгийн 1, Орхон аймгийн Жаргалант сум 114.9 сая төгрөгийн 1, Увс аймгийн Сагил сум 116.0 сая төгрөгийн 1 худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авсан, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум 38.0 сая төгрөгийн 1, Хатгал тосгон 74.8 сая төгрөгийн 1 ажлын худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулалгүй шууд худалдан авсан;

- ✓ Баянхонгор аймгийн Баянлиг сумын ИТХ-аар 100.0 сая төгрөгөөр баталсан 1 ТАХ-г 57.2 сая төгрөгөөр, Баянговь сумын ИТХ-аар 120.0 сая төгрөгөөр баталсан ТАХ-ний худалдан авах ажиллагааг 100.0 сая төгрөгөөр тус тус зарласан;
- ✓ Баянхонгор аймгийн Баацагаан сум 84.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээнд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй аж ахуйн нэгжийг шалгаруулсан, үнэлгээний хорооны гишүүн ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг бүрэн бөглөөгүй, үнэлгээний хороонд оролцоогүй байхад нь оролцсоноор хурлын тэмдэглэл хөтөлсөн;
- ✓ Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2, Эрдэнэцогт сумын ОНХС-д эрх шилжүүлсэн 1, Баянбулаг сумын 305.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд шилжүүлээгүй;
- ✓ Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ОНХС-ийн худалдан авах ажиллагааны баримтад нийт 14 ажлын хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
- ✓ Баянхонгор аймгийн Галуут, Баян-Овоо, Баянлиг, Жаргалант, Бөмбөгөр, Өлзийт, Баянбулаг Баян-Өндөр сумд нийт 1,036.4 сая төгрөгийн 8, Говьсүмбэр аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 100.0 сая төгрөгийн 1, Орхон аймгийн Жаргалант сум 150.0 сая төгрөгийн 1 ТАХ-нд худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн;
- ✓ Говь-Алтай аймгийн ОНХС болон Алтай, Баян-Уул, Бигэр, Дарви, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмана, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумууд тендерийн баримт бичигт урьдчилгаа төлбөрийг олгохооргүй заасан байхад гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд урьдчилгаа төлбөрийг олгохоор тусгаж санхүүжүүлсэн;
- ✓ Говь-Алтай аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд Жаргалан, Цогт, Чандмань сум, Цогт сумын Баянтоорой тосгонд "Нийтийн эзэмшлийн бие засах байгууламж барих" 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4, 2024 онд "Баян-Уул сумын 5 багт мал угаалгын ванн барих" 99.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээний тендерт "Нутгийн оргил Групп" ХХК шалгарч гэрээ байгуулан урьдчилгаа төлбөрт 99.1 сая төгрөг олгосон боловч огт ажил хийгдээгүй;
- ✓ Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум 44.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-нд харьцуулалтын арга ашиглан 38.3 сая төгрөгийн гэрээ байгуулан худалдан авалт хийсэн ч нэмэлтээр 5.8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн;
- ✓ Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум 528.2 сая төгрөгийн 4, Шивээговь сум 1,199.2 сая төгрөгийн 5 ажлын гэрээнд гүйцэтгэлийн баталгааны баримт ирүүлэх тухай заалтыг тусгаагүй;
- ✓ Дундговь аймгийн сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн болон чанарын баталгааг тусгуулаагүй, худалдан авах ажиллагааг үр дүнтэй хуулийн дагуу зохион байгуулаагүй;
- ✓ Дорнод аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1,197.9 сая төгрөгийн 5, Халх гол сум 670.8 сая төгрөгийн 7, Матад сум 733.0 сая төгрөгийн 5, Булган сум 80.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээнд НДШ, татварын өртэй аж ахуйн нэгжийг шалгаруулсан;
- ✓ Дорнод аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 961.9 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээнд бусад шаардлага буюу тусгай зөвшөөрөл, тендерийн баталгаа, ажлын туршлага зэргийг хангаагүй аж ахуйн нэгжийг шалгаруулж гэрээ байгуулсан бол худалдан авах ажиллагааны баримтуудад хурлын тэмдэглэл, лавлагаа, тодорхойлолт, мэдэгдэл зэргийг дутуу хавсаргасан, тендерийн баримт бичгийг аргачлалын дагуу боловсруулдаггүй, үр дүнг цахим системд нийтлээгүй зөрчил нийтлэг байна.
- ✓ Орхон аймгийн Жаргалант суманд цэцэрлэг байгуулах ажилд 970.0 сая төгрөг баталсан ч 1,290.2 сая төгрөгөөр худалдан авах ажиллагааг зарлан, гүйцэтгэгчтэй 1,282.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан;
- ✓ Өвөрхангай аймгийн Арвайхээр сум 332.8 сая төгрөгийн 1, Төгрөг сум 68.0 сая төгрөгийн 1, Тарагт сум 50.0 сая төгрөгийн 1, Баянгол сум 33.6 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтод бараа, үйлчилгээний нэрийг тухайлан заасан;
- ✓ Өвөрхангай аймгийн Арвайхээр сум 2,320.8 сая төгрөгийн 3, Өмнөговь аймгийн Баян-Овоо сум 148.2 сая төгрөгийн 1, Нийслэлийн Баянгол дүүрэг 99.4 сая төгрөгийн 1, Баянзүрх дүүрэг 1,256.5 сая төгрөгийн 4, Налайх дүүрэг 187.5 сая төгрөгийн 2, Сүхбаатар дүүрэг 851.8 сая төгрөгийн 2, Хан-Уул дүүрэг 3,566.4 сая төгрөгийн 4, Чингэлтэй дүүрэг 122.2 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээнд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуурыг бүрэн хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан;

- ✓ Өвөрхангай аймгийн Арвайхээр сум 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээнд үнэлгээний хороо шийдвэрээ 22 хоногт гаргасан;
- ✓ Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим ТАХ-ний машин, механизм, хүний нөөц болон тоног төхөөрөмжийн шаардлагыг хассан, өөрчилсөн, мөн үнэлгээний хорооны хурлаар оролцогчид тавигдах шаардлага, зарлал, урилга хэлэлцсэн тухай хурлын тэмдэглэл байхгүй;
- ✓ Өвөрхангай аймгийн Сант сум 40.0 сая төгрөгийн 1, Баянгол сум 35.0 сая төгрөгийн 1, Зүүнбаян-Улаан сум 50.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний үнэлгээний хороо оролцогчид тавих шаардлагыг хэлэлцээгүй, ажлын тоо хэмжээг бууруулсан;
- ✓ Өвөрхангай аймгийн Баянгол сум 4, Зүүнбаян-Улаан 2 төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг бүрэн бөглөөгүй;
- ✓ Өмнөговь аймгийн Номгон сум “ЕБС-ийн биеийн тамирын талбайд тоглоомын талбай тохижуулах ажил”-ын даалгаварт тоног төхөөрөмжийг суурилуулахад шаардлагатай бараа, материалыг төлөвлөөгүй;
- ✓ Өмнөговь аймгийн Баян-Овоо сум 2, Манлай сум 124.5 сая төгрөгийн 7, Ханхонгор сум 37.0 сая төгрөгийн 1, Цогт-Овоо сум 42.8 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг гүйцэтгэх үнийн саналыг олон нийтэд мэдээлээгүй, чөлөөт өрсөлдөөнөөр нээлттэй сонгон шалгаруулаагүй;
- ✓ Өмнөговь аймгийн Манлай сум "Сургуулийн 420 хүүхдийн ширээ сандлыг шинэчлэх", "Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж авах" зэрэг ажлын тендер шалгаруулалтын баримт бичиг болон гэрээнд барьцаа хөрөнгө байршуулах талаар тусгаагүй;
- ✓ Өмнөговь аймгийн Ханхонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Бэлчээрийн гүн өрмийн худгийн цооног нэмэгдүүлэх худаг гаргах ажил”-ын үнэлгээний хорооны 3 гишүүн ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гаргаагүй, "Жижиг дунд үйлдвэрийн барилга өргөтгөх хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж суурилуулах, хадгалах агуулах барих ажил”-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар сумын ЗДТГ-ын дарга томилогдож, үнэлгээний хорооны зөвлөмж гарган ЗДТГ-ын даргын албан бичгээр гэрээ гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгосон;
- ✓ Өмнөговь аймгийн Баяндалай сум 50.2 сая төгрөгийн 61, Ноён сум 128.0 сая төгрөгийн 55, Сэврэй сум 80.7 сая төгрөгийн 36 ширхэг барааг худалдан авах цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулсан;
- ✓ Сүхбаатар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тендерт оролцогчдын ирүүлсэн нэгж өртгийн төсвийг хяналтын төсвийн нэгж өртөгтэй харьцуулан үндэслэлгүй зөрүүтэй санал ирүүлсэн эсэхийг шалгаж, шаардлагад нийцсэн эсэхийг үнэлдэггүй;
- ✓ Сэлэнгэ аймгийн Шаамар сум 106.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш 7 сарын дараа тендерийг зарлаж, 5.8 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байхад тендерт шалгарсан “Эл Си Би” ХХК-тай гэрээ байгуулсан;
- ✓ Төв аймгийн Баян-Өнжүүл, Баянцагаан, Лүн, Жаргалант сумд худалдан авах ажиллагааг хууль дүрмийн дагуу зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны нарийн бичиг худалдан авах ажиллагааны баримт бичгийг стандарт, дэс дараалал, тавигдах шаардлагуудыг журмын дагуу хөтөлж ажиллаагүй;
- ✓ Төв аймгийн Баян-Өнжүүл сум 303.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлахдаа захиалагчийн хяналтын батлагдсан төсөвгүй зарласан;
- ✓ Төв аймгийн Баянчандмань сум 318.9 сая төгрөгийн 2, Борнуур сум 50.0 сая төгрөгийн 1, Цээл сум 4, Өндөрширээт сум 40.6 сая төгрөгийн 3, Эрдэнэ сум 114.0 сая төгрөгийн 5, Эрдэнэсант сум 58.5 сая төгрөгийн 3, Жаргалант сум 199.9 сая төгрөгийн 5, Мөнгөнморьт сум 135.5 сая төгрөгийн 9 зураг, төсөвгүй төсөл арга хэмжээг баталж, худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гэрээ байгуулсан;
- ✓ Төв аймгийн Баянцагаан сум 71.6 сая төгрөгийн 5, Ховд аймгийн Үенч, Мөнххайрхан сумд 33.5 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг шууд худалдан авахдаа захиалагчийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй гэрээ байгуулсан;
- ✓ Төв аймгийн Баян-Өнжүүл сум 99.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээг тоног төхөөрөмж нийлүүлэх, засварын ажил гэж 2 хуваан худалдан авах ажиллагааг зарлаж, тодотголоор техник хэрэгсэл худалдан авахад 20.0 сая төгрөг батлуулж засварын ажил гүйцэтгэгчээр шалгарсан компаниар дамжуулан шууд худалдан авалтаар гэрээ байгуулалгүй зарцуулсан;

- ✓ Ховд аймгийн Алтай сум тендерийн баримт бичигт санхүүгийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх талаар заагаагүй;

Дээрх илэрсэн алдаа зөрчлийг өмнөх онтой харьцуулахад зөрчлийн мөнгөн дүн 8.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт №9: Алдаа зөрчлийн харьцуулалт:

Үзүүлэлт	Аудитаар илэрсэн алдаа зөрчил			
	2023 он		2024 он	
	Тоо	Дүн /сая.төг/	Тоо	Дүн /сая.төг/
Төлбөрийн акт	-	-	1	8.9
Албан шаардлага	19	1,665.2	56	10,300.7
Зөвлөмж	75	731.6	50	8,639.8
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	6	64.0	3	1,270.3
Нийт	100	2,460.8	110	20,219.7

Эх сурвалж: “ОНХС-ийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” аудитын тайлан, судалгаа

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнгээс үзэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж, засаг даргын захирамжаар зохион байгуулагдсан үнэлгээний хороод худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, тогтоомжийн дагуу, хариуцлагатай ажиллаагүйгээс зөрчил давтагдан гарсаар байна. Иймд үнэлгээний хороо, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, сургалт зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, баримт бичгийн бүрдлийг сайжруулах, ТАХ-ний төлөвлөлт, ТЭЗҮ, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 20,219.7 сая төгрөгийн зөрчилд 8.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 10,300.7 сая төгрөгийн 56 албан шаардлага хүргүүлж, 8,639.7 сая төгрөгийн 50 зөвлөмжийг өгч, 1,270.3 сая төгрөгийн 3 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ. (Дэлгэрэнгүйг [хавсралт №-2.1.1](#)-оос харна уу)

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг шууд худалдаж авах, харьцуулалтын арга хэрэглэх зорилгоор төсөвт өртгийг хуваасан, шаардлага хангаагүй буюу татвар, нийгмийн даатгалын өртэй, тусгай зөвшөөрөл, ажлын туршлага, тендерийн баталгаа ирүүлээгүй аж ахуйн нэгжийг гүйцэтгэгчээр шалгаруулсан нь төсөл арга хэмжээний гүйцэтгэл, чанар, хөрөнгийн үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийг ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн үр нөлөөтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2.1.2 Улсын хэмжээнд 2024 онд 8,998 төсөл арга хэмжээнд 523,461.3 сая төгрөгийн санхүүжилт олгосны 89.8 хувь буюу 8,082 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 10.2 хувь буюу 916 төсөл арга хэмжээ хэрэгжих шатанд байна. (Дэлгэрэнгүйг [судалгаа 3-аас харна уу.](#))

ОНХС-ийн эх үүсвэрийн малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт 6,864.2 сая төгрөгөөр тасарсан, зарласан тендерт оролцогч ирээгүйгээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон, оройтсон, төсөвт өртөг хүрэлцээгүй зэргээс шалтгаалан 1,987 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хүснэгт №10: ОНХС-ийн 2024 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ

(сая төгрөг)

Аймгийн нэр	ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, ТАХ-ний	Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний	Бүрэн хэрэгжсэн ТАХ-ний	Дутуу хэрэгжсэн ТАХ-ний	Огт хэрэгжээгүй ТАХ-ний
-------------	--	--	-------------------------	-------------------------	-------------------------

	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн	Тоо	Дүн
Аймаг	10,413	677,500.3	8,649	638,325.2	7,759	436,747.8	878	200,830.1	1819	109,508.8
Нийслэл	529	72,959.6	410	69,508.0	323	51,239.1	38	8,199.5	168	23,373.9
Нийт	10,942	750,459.9	9,059	707,833.2	8,082	487,986.9	916	209,029.6	1987	132,882.7

(Дэлгэрэнгүйг судалгаа 3-аас харна уу)

ОНХС-аас хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгодоггүй, зориулалт бус зарцуулдаг, гэрээний дагуу алданги тооцдоггүй, чанаргүй дутуу гүйцэтгэдэг зөрчил давтагдан гарсаар байна. Мөн аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлаагүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүжилт олгожээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5³³, 41 дүгээр зүйлийн 41.2.2³⁴, 60 дугаар зүйлийн 60.3³⁵, Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7³⁶, 8.5³⁷, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12³⁸ дахь заалт, гүйцэтгэгч захиалагчийн хооронд байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Гэрээний алданги тооцоогүй ТАХ:

- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 6 төсөл арга хэмжээнд алданги тооцоогүй, Баян-Өндөр сум тендерийн баримт бичигт гүйцэтгэгчийн төлөх алдангийг заасан ч гэрээнд алдангийн хэмжээг өөрөөр тусгасан;
- ✓ Булган аймгийн Сайхан сум 358.0 сая төгрөгийн 3, Хутаг-Өндөр сум 174.0 сая төгрөгийн 3, нийт 532.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ хугацаа хэтрүүлсэн байхад алданги тооцоогүй;
- ✓ Орхон аймаг нийтийн тээврийн автобус худалдан авах төсөл арга хэмжээнд 26.8 сая төгрөгийн алданги тооцох нөхцөлийг хүчингүй болгосон;
- ✓ Өмнөговь аймгийн Номгон сум 1 төсөл арга хэмжээнд 11.7 сая төгрөг, Даланзадгад сум 1 төсөл арга хэмжээнд 1.5 сая төгрөг, Баян-Далай сум 4 ТАХ-нд 11.4 сая төгрөг, Ноён сум 4 төсөл арга хэмжээнд 2.3 сая төгрөг, Сэврэй сум 4 ажилд 11.3 сая төгрөгийн алданги тооцоогүй;
- ✓ Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Цагааннуур сумд гэрээний хугацаа хэтэрсэн 9 төсөл арга хэмжээнд 2.8 сая төгрөгийн алданги тооцоогүй;
- ✓ Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Буянт, Үенч сумууд ажил гүйцэтгэх гэрээнд чанарын баталгаат хугацаа, барьцаа хөрөнгө суутгах, алданги тооцох заалт оруулаагүйгээс хугацаа хэтэрсэн ТАХ-нд алданги тооцоогүй;
- ✓ Хэнтий аймгийн Баянхутаг сум 6 төсөл арга хэмжээнд 5.8 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 3 төсөл арга хэмжээнд 2.8 сая, Батноров 3 төсөл арга хэмжээнд 14.3 сая төгрөг, Баян-Овоо сум 2 төсөл арга хэмжээнд 2.8 сая төгрөг, Жаргалтхаан сум 3 төсөл арга хэмжээнд 2.5 сая төгрөгийн алданги тус тус тооцоогүй, гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжүүлсэн;

Гэрээ дүгнээгүй, ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгоогүй ТАХ:

- ✓ Архангай аймгийн Ихтамир сум 511.6 сая төгрөгийн 20, Өгийнуур сум 269.9 сая төгрөгийн 6, Цэнхэр сум 1,012.1 сая төгрөгийн 24 ТАХ-ний гэрээг дүгнээгүй, ажлын даалгаварт заагдсан ажил бүрэн хийгдээгүй байхад Хайрхан сум 3.9 сая төгрөгийн 1,

³³ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

³⁴ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

³⁵ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:

³⁶ Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй:

³⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно.

³⁸ Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно

- Эрдэнэмандал сум 73.7 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээнд санхүүжилтийг бүрэн олгосон;
- ✓ Архангай аймгийн Цэцэрлэг сум 73.9 сая төгрөг, Тариат сум 29.8 сая төгрөг тус бүр 1 ТАХ-нд урьдчилгаа олгосон боловч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй;
 - ✓ Баян-Өлгий аймгийн Улаанхус сум 48.0 сая төгрөгийн 4 ТАХ-нд урьдчилгаа санхүүжилт олгосон боловч огт хэрэгжилт байхгүй, Бугат сум 1 ТАХ-нд 3.5 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй;
 - ✓ Баянхонгор аймгийн Баян-Овоо сум 29.0 сая төгрөгийн авлагад өвс тэжээлийг хүлээн аваагүй атлаа орлогоор бүртгэж, авлагыг хаасан, Баацагаан сум 1 төсөл арга хэмжээнд хийгдээгүй ажилд 0.5 сая төгрөг тооцож олгосон, Өлзийт сум 1 төсөл арга хэмжээнд 9.0 сая төгрөгийг гэрээний дагуу урьдчилгаа олгосон боловч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй, Баянхонгор сум тайлан ирүүлээгүй шалтгаанаар 1 ТАХ-ний үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй, тус ажлыг хүлээн аваагүй, Гурванбулаг сум 71.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ТАХ-нд зураг төсөвт тусгагдсан ажлууд дутуу хийгдсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Баацагаан сум 1 ТАХ-нд санхүүжилтийн 60 хувийг урьдчилан олгож, ажлыг хүлээн авсны дараа 40 хувийг олгохоор заасан ч ажил хүлээлцээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;
 - ✓ Говь-Алтай аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд Жаргалан, Цогт, Чандмань сум, Цогт сумын Баянтоорой тосгонд хэрэгжүүлэх 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4, 2024 онд Баян-Уул суманд хэрэгжүүлэх 99.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ний гүйцэтгэгч “Нутгийн оргил Групп” ХХК-нд 99.1 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч огт ажил хийгдээгүй, Тайшир, Халиун, Цогт сумууд 55.6 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээнд бодит гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгоогүй, Дарив сум 1 ТАХ-нд 4.4, Төгрөг сум 1 ТАХ-нд 1.2 сая төгрөгийг тус тус илүү олгосон, Халиун сум 5 ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэлгүйгээр санхүүжилтийн 20.5 сая төгрөгийг 100 хувь урьдчилж олгосон, “Газрын нэрийн тодруулгын зардал” ТАХ-нд 15.0 сая төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлийг үндэслэлгүй бүрэн олгосон ч ажил огт хийгдээгүй, “Нэн яаралтай үеийн үнэлгээ болон тусламж үйлчилгээ сургалт” төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны А/739 дугаар захирамжаар Эрүүл мэндийн газарт гэрээ байгуулах эрх олгосон боловч оны эцэст 19,950,000.00 төгрөгийн санхүүжилтийг “Анар дент” ХХК руу гэрээ байгуулалгүйгээр шилжүүлсэн, сургалт арга хэмжээг зохион байгуулсан тайлангүй, анхан шатны нотлох баримтаар нотлогдоогүй;
 - ✓ Говьсүмбэр аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн 53.9 сая төгрөгийн 2, Сүмбэр сум 23.7 сая төгрөгийн 4, Баянтал сум 127.0 сая төгрөгийн 3, нийт 204.6 сая төгрөгийн 9 ТАХ-нд бодит гүйцэтгэлээр санхүүжилтийг олгоогүй;
 - ✓ Дархан-Уул аймгийн Хонгор сум 2 төсөл арга хэмжээнд 8.6 сая төгрөг, Дархан сум 1 төсөл арга хэмжээнд 1.0 сая төгрөгийг бодит гүйцэтгэлд үндэслэлгүй илүү тооцож олгосон, Хонгор сум 1,108.3 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээнд хүлээн авах комиссын үүрэг даалгаврыг биелүүлээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Дархан сум 1 төсөл арга хэмжээнд урьдчилгаа 16.0 сая төгрөг олгосон боловч хэрэгжилт байхгүй;
 - ✓ Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын ИТХ-аар баталсан 19.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэгчийн орыг нэмэгдүүлэх” ажлыг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа 0.2 сая төгрөгөөр илүү дүнгээр байгуулсан;
 - ✓ Завхан аймгийн Их-Уул сум 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд гүйцэтгэгч компанид 411.8 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй;
 - ✓ Орхон аймгийн Баян-Өндөр сум Зэст багт хийгдэж байгаа авто замын их засварын ажилд гэрээний үнийн дүнгийн 30 хувь болох урьдчилгаанд 478.9 сая төгрөг олгосон хэдий ч тухайн гүйцэтгэгчид давуу байдал үүсгэж, урьдчилгаа төлбөрийг тооцохгүйгээр 368.8 сая төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтийг дахин нэмж олгосон;
 - ✓ Өвөрхангай аймгийн Арвайхээр сум Эко нойл төсөл хэрэгжүүлж 446.5 сая төгрөгийн санхүүжилт олгохдоо бодит гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй, чанаргүй хийгдсэн, Арвайхээр, Бат-Өлзий, Богд сум 4 төсөл арга хэмжээнд 1,406.2 сая төгрөг олгохдоо бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй;

- ✓ Өмнөговь аймгийн Номгон сум 6.8 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Цогт-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Дахин дамжуулах ЦТП байгуулах" ажил эхлүүлээгүй байхад 70 хувийн урьдчилгаа санхүүжилтэд 27.8 сая төгрөгийг гэрээнд тусгаж, санхүүжилт хүссэн албан бичгийг үндэслэн олгосон, Ноён сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Сумын үер усны далан шуудуу барих ажил"-ыг шаардлага хангаагүй иж бүрдэл дутуу баримт бичгийг үндэслэн санхүүжилт олгосон, Хүрмэн сум худаг засварлах ажлын 5.0 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг барьцаа данс руу төвлөрүүлсэн байна;
- ✓ Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум 86.0 сая төгрөгийг 1, Наран сум 300.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээнд бодит гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжилтийг олгоогүй;
- ✓ Сэлэнгэ аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2 ТАХ-нд анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад магадалшгүй ажлын зардалд 18.2 сая, Орхонтуул, Сайхан, Цагааннуур сумд 10 төсөл арга хэмжээнд 19.9 сая, мөн аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг техникийн үзүүлэлт, тоо ширхгээр нь тулгаж хүлээн аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, 2 ТАХ-нд 12.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж дутуу нийлүүлэгдсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Баруунбүрэн сум 1 төслийн хүрээнд нийлүүлэгдэх тавилга хэрэгслийг хүлээж аваагүй байхад 39.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон, Түшиг, Хушаат, Цагааннуур сумд төсөл арга хэмжээг ИТХ-аар баталсан төсвөөс 10.9 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн, Цагааннуур сум 2 төсөл арга хэмжээнд 2.7 сая төгрөгийн захиалагчийн хяналтыг зардлыг нотлох баримтгүй олгосон, Баруунбүрэн сум 1 төсөл арга хэмжээний гэрээ дүгнэсэн акт болон хүлээн авсан актад ажлын хэсэг хүлээн авч гарын үсэг зурж баталгаажуулаагүй байхад 126.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон, гэрээний биелэлт, үр дүнг “Гэрээ дүгнэх маягт”-аар үнэлж, баталгаажуулалгүйгээр 9 сум 50 төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгосон, Жавхлант сум 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Төрийн албан хаагчийн байр худалдан авах" төсөл арга хэмжээний газрын гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй, Орхонтуул сум “Явуулын иргэний танхим” төслөөр автомашин худалдан авахдаа зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан;
- ✓ Төв аймгийн Зуунмод сум 2 ажилд 11.0 сая, Баянхангай сум 1 ажилд 11.0 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон, Лүн сум 1 төсөл арга хэмжээний хяналтын төсвийг 58.8 сая төгрөгөөр хэтрүүлэн 175.4 сая төгрөгийн гэрээ байгуулж санхүүжилт олгосон, Баян-Өнжүүл сум гадна хашааны оронд адууны хашааг 2.4 сая төгрөгөөр, үүдний тек 4ш авахаас 3ш нь ирээгүй 1.5 сая төгрөгийг компанид төлсөн, Алтанбулаг, Архуст, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт, Сүмбэр, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, Баянхангай, Баянчандмань, Жаргалан, Баянцагаан, Лүн сумууд хөрөнгө оруулалтын ажилд гэрээ байгуулсан өдөр буюу ажил нь хийгдээгүй, ажлын гүйцэтгэл гараагүй байхад 70-100 хувийн урьдчилгаа санхүүжилтэд нийт 3,296,3 сая төгрөг олгосон, Дэлгэрхаан сум 104.0 сая төгрөгийн 1, Баян-Өнжүүл сум 199.3 сая төгрөгийн 1 ТАХ-г комиссын актаар хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Төв аймгийн Алтанбулаг сум халуун усны тохижилтын ажилд 12.6 сая төгрөг батлагдсан байхад 15.0 сая төгрөгөөр гэрээ байгуулж, батлагдсан төсвийг 2.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн;
- ✓ Увс аймгийн Түргэн сум Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй, гамшгийн бэлэн байдлын зэрэгт шилжээгүй байхад сумын ИТХ-аар батлуулсан "Гамшгийн эрсдэлийг бууруулах" төсөл арга хэмжээний хүрээнд нотлох баримтгүйгээр тээвэр шатахууны зардалд 9.8 сая зарцуулсан, аймгийн ИТХ-аар Зураг төсөв, геологи судалгааны зардалд 334.1 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 139.9 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан, аймгийн ОНХС-аас 289.3 сая төгрөгийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн, Наранбулаг сум 7.6 сая төгрөг, Малчин сум 8.1 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарцуулсан;
- ✓ Ховд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Ховд BOX” төсөлд 352.0 сая төгрөг, Жаргалант сум “Сангийн хэрэм тохижилт”-д 176.3 сая төгрөг, Сүү боловсруулах үйлдвэрийн зураг төсвийг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, Эрдэнэбүрэн сум 102.0 сая төгрөг, Жаргалант сум 116.5 сая төгрөг, Үенч сум 56.0 сая төгрөг, Буянт сум 59.8 сая төгрөгийг тус бүр 1 төсөл арга хэмжээнд урьдчилгаа олгосон боловч гэрээнд заасан

хугацаанд ажил гүйцэтгээгүй, Буянт, Үенч, Цэцэг, Эрдэнэбүрэн, Дарви сумууд ОНХС-аар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээнд урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэлд үндэслэн олгоогүй;

- ✓ Хөвсгөл аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2 төсөл арга хэмжээний 5.7 сая төгрөг, Мөрөн сум 1 төсөл арга хэмжээнд 1.3 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон;
- ✓ Хэнтий аймгийн Дархан сум 15.0 сая төгрөгийн гэрээтэй 1 ажилд 10.5 сая төгрөг олгосон боловч ажил хийгдээгүй, малын тэжээл нийлүүлэх 9.9 сая төгрөгийн гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон боловч 6.2 сая төгрөгийн тэжээл гэрээнд заасан хугацаанд нийлүүлэгдээгүй;

Зориулалт бус зарцуулсан ТАХ:

- ✓ Архангай аймаг 19.9 сая төгрөг, Баян-Өлгий аймаг 76.0 сая төгрөг, Баянхонгор аймаг 0.6 сая төгрөг, Говь-Алтай аймаг 17.1 сая төгрөг, Дорноговь аймаг 34.6 сая төгрөг, Дорнод аймаг 2.0 сая төгрөг, Орхон аймаг 0.3 сая төгрөг, Өвөрхангай аймаг 49.5 сая төгрөг, Өмнөговь аймаг 198.3 сая төгрөг, Төв аймаг 596.6 сая төгрөг, Увс аймаг 25.0 сая төгрөг, Ховд аймаг 4.0 сая төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Чанаргүй буюу дутуу гүйцэтгэлтэй ТАХ:

- ✓ Баян-Өлгий аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 789.4 сая төгрөгийн 2, Улаанхус сум 8.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн хэрэгжээгүй;
- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ны хүрээнд бий болсон хөрөнгийг иргэдэд олгосон анхан шатны баримт байхгүй, "Шуурхай удирдлагын төвийг байгуулах" ажлын хөргүүрийн системийг байршуулаагүй, Баянговь суманд 39.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй биеийн тамирын талбайн тохижилтын ажил хийхдээ гар бөмбөгийн талбайг 40.5мкв дутуу хийсэн, Баянлиг сум 1 ТАХ-нд гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй тоног төхөөрөмж нийлүүлсэн, 97.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ТАХ-г гэрээний хугацаанд хүлээлгэн өгөөгүй, ажлыг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй, хийгдсэн ажлууд чанаргүй, дутуу байхад захиалагч байгууллагаас ямар нэгэн арга хэмжээ аваагүй, иргэн Б.Мөнхжаргалтай 2 дугаар багийн төвийн урсгал засварын ажлыг гүйцэтгэхээр 13.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байхад ажлыг хүлээлгэн өгөөгүй, Бууцагаан сум "Нийтийн эзэмшлийн талбайд авто зам барих, хашлага хийх" ажилд гүйцэтгэгчид 94.3 сая төгрөгийн санхүүжилт олгож гэрээг 2023, 2024 онд сунгасан бөгөөд чанар муу хийгдсэн шалтгаанаар ажлыг хүлээж аваагүй, Эрдэнэцогт сум иргэн Э.Жагваралтай гэрээ байгуулж 19.9 сая төгрөгийн ажилд, 17.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон ч ажил дутуу, хугацаандаа хүлээлгэж өгөөгүй, Баацагаан сумын 1 ТАХ-ний 8,0 сая төгрөгийн зарцуулалтын тайлан анхан шатны баримт байхгүй;
- ✓ Булган аймгийн Тэшиг сум дулааны шугам солих ажлыг зургийн дагуу гүйцэтгээгүй;
- ✓ Говь-Алтай аймгийн Баян-Уул 34.8 сая төгрөгийн 1, Бигэр сум 107.1 сая төгрөгийн 8, Жаргалан сум 39.8 сая төгрөгийн 2, Тайшир сум 9.8 сая төгрөгийн 1, Төгрөг сум 8, Цээл сум 1, Чандмана сум 4, Шарга сум 20.0 сая төгрөгийн 1, Эрдэнэ сум 2, Есөнбулаг сум 3 төсөл арга хэмжээ, дутуу, ажлын даалгавар, зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй;
- ✓ Дархан-Уул аймгийн Дархан сум 1, Хонгор сум 1 төсөл арга хэмжээ чанаргүй хийгдсэн;
- ✓ Завхан аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 503.9 сая төгрөгийн 4, Нөмрөг, Отгон, Сонгино, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Тосонцэнгэл сумууд 251.0 сая төгрөгийн 6, нийт 754.9 сая төгрөгийн 10 ТАХ гэрээний хугацаанд бүрэн дуусаагүй;
- ✓ Өвөрхангай аймгийн ОНХС болон Хайрхандулаан, Сант, Уянга сумууд 522.6 сая төгрөгийн 5 ТАХ гэрээний хугацаанд бүрэн дуусаагүй, аймгийн ОНХС болон Баянгол, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Нарийнтээл, Арвайхээр, Тарагт, Хужирт, Богд, Зүүнбаян-Улаан, Гучин-Ус, Хархорин, Есөнзүйл сумдад хэрэгжүүлсэн 3,293.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 ТАХ нь чанаргүй, хийгдсэн ажлууд техникийн тодорхойлолтоос зөрүүтэй, бараа дутуу нийлүүлэгдсэн;

- ✓ Өмнөговь аймгийн Цогтцэций сум Захиалагчийн ажлын зурагт тусгагдсан ажил дутуу хийгдсэн байхад улсын комисс хүлээж авсан;
- ✓ Увс аймаг болон сумдын ОНХС-аар хэрэгжүүлсэн 2,510.0 сая төгрөгийн 41 ТАХ хэрэгжилт дутуу,
- ✓ Ховд аймгийн ОНХС-аас 8 төсөл арга хэмжээнд 776.1 сая төгрөг олгосон боловч гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгжээгүй;

Гэрээний үнийн дүнгээс илүү санхүүжүүлсэн ТАХ-ний тухайд:

- ✓ Баянхонгор аймгийн ОНХС болон Баацагаан, Шинэжинст сумын ОНХС-аас 3 ТАХ-ний гүйцэтгэгчид зураг төсөв, зохиогчийн хяналтын зардлын нийт 10.9 сая төгрөгийг шилжүүлсэн;
- ✓ Орхон аймаг захиалагчийн хяналтын зардалд болон урамшууллыг гэрээний үнийн дүнгээс 139.8 сая төгрөгөөр илүү тооцож санхүүжилт олгосон, Баян-Өндөр суманд хийгдэх авто замын их засварын ажилд гүйцэтгэгчээр шалгарсан “Ингүүмэл зам” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулахдаа үнийн хөнгөлөлт тооцоогүй 1,525.2 сая төгрөг буюу 9.0 сая төгрөгөөр илүү дүнгээр гэрээ байгуулсан;
- ✓ Төв аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн 3 ажилд 12.5 сая төгрөг, Баянжаргалан сум 4 ажилд 3.4 сая төгрөг, Баянчандмань сум 1 ажилд 4.2 сая төгрөг, Жаргалан сум 1 ажилд 1.7 сая төгрөгийг тус тус зохиогчийн болон захиалагчийн хяналтын зардлыг илүү тооцож олгосон;

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн төсөл арга хэмжээ:

- ✓ Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Буянт хөрс наран" ХХК-ийн гүйцэтгэж байгаа орон нутгийн барилгын их засварын ажлыг аймгийн ГХБХБГ-аас зогсоох албан бичгийг захиалагч байгууллагад хүргүүлсэн байхад тус компанид 38.9 сая төгрөгийг олгосон бөгөөд тус компанитай холбоотой асуудлыг захиалагчаас хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн;

Ажлын даалгавар, зураг төсөвгүй ТАХ-ний тухайд:

- ✓ Говь-Алтай аймгийн Баян-Уул, Бугат, Дарив, Дэлгэр, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмана, Шарга, Эрдэнэ сумд ажлын даалгаваргүй 557.2 сая төгрөгийн 45, Бугат, Дэлгэр, Төгрөг, Цогт, Чандмана, Шарга, Эрдэнэ сумд ажлын даалгавар тодорхой бус 857.0 сая төгрөгийн 45, Бугат, Эрдэнэ, Шарга, Тайшир, Цогт сумууд 879.7 сая төгрөгийн 10, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 334.3 сая төгрөгийн 3 ТАХ-г зураг төсөвгүйгээр ажлын даалгавраар тендер зарлан шалгаруулж, гүйцэтгүүлсэн;
- ✓ Ховд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөвгүй 150.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг баталж, нэмэлтээр 299.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан, зураг нь магадлалаар баталгаажуаагүй 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн;

Чанарын баталгаатай холбоотой:

- ✓ Орхон аймгийн Жаргалант сум 2 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн чанарын баталгааны хугацаа дуусаагүй байхад нийт 284.3 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгосон;
- ✓ Өмнөговь аймгийн Ханбогд сум “Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд гэрэлтүүлэг, камержуулалд хийх” ажил гүйцэтгэх гэрээний дагуу 19.9 сая төгрөгийг сумын барьцаа сангийн дансанд байршуулаагүй;
- ✓ Өмнөговь аймгийн Ханхонгор сум "Сумын 100 жилийн ой болохтой холбогдуулан айл өрх байгууллагын хаягжуулалд барилга байгууламжийн өнгө үзэмжийг сайжруулах гадна хашаа шинэчлэх" ажлаас барьцааг хуульд заасан хувь хэмжээнээс багаар буюу 2 хувиар тооцож байршуулсан;
- ✓ Өмнөговь аймгийн Хүрмэн сумын ОНХС-аас хэрэгжүүлэх 3 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээнд 1.8 сая төгрөгийн барьцаа суутгахаар заасан байхад суутгаагүй;

ИТХ-аар батлаагүй ТАХ-нд санхүүжилт олгосон:

- ✓ Увс аймгийн Өндөрхангай сум 14.0 сая төгрөгийн 2, Цагаанхайрхан сум 5.9 сая төгрөгийн 1, Тэс сум 4.8 сая төгрөгийн 1,
- ✓ Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум 1,550.2 сая төгрөгийн 1, Дэлгэр сум 13.3 сая төгрөгийн 3, Дарив сум 10.5 сая төгрөгийн 1, Тайшир сум 10.5 сая төгрөгийн 1, Тонхил сум 10.0 сая төгрөгийн 1, нийт 1,594.4 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн.

- ✓ Дорноговь аймгийн Улаанбадрах сум 134.4 сая төгрөгийн 1, Мандах сум 14.3 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн;
- ✓ Өмнөговь аймгийн Баян-Овоо 29.7 сая төгрөгийн 1, Манлай сум 40.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн;
- ✓ Сэлэнгэ аймгийн Шаамар, Цагааннуур, Хушаат сумууд 104.4 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн;
- ✓ Орхон аймаг 223.6 сая төгрөгийн зураг төсөв хийлгэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн;

Дээрх алдаа зөрчлүүдийн 56.7 хувь буюу 10,526.9 сая төгрөгийг төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй, 4.8 хувь буюу 906.2 сая төгрөгийг зориулалт бус зарцуулалт, 3.3 хувь буюу 628.6 сая төгрөгийг ИТХ-аар батлаагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчил байгаа бол 35.2 хувь буюу 6,518.4 сая төгрөгийг бусад алдаа зөрчил эзэлж байна. (Дэлгэрэнгүйг [хавсралт №2.1.2-оос харна уу](#))

Хүснэгт №11: Алдаа зөрчлийн харьцуулалт:

№	Үзүүлэлт	2022 он (сая.төг)	2023 он (сая.төг)	2024 он (сая.төг)
1	Төлбөрийн акт	155.1	289.4	806.3
2	Албан шаардлага	2,117.9	5,406.6	17,109.9
3	Зөвлөмж	58.1	494.0	1,210.2
4	Хуулийн хяналтад	-	63.9	358.8
Нийт дүн		2,331.1	6,253.9	19,485.2

Дээрх алдаа зөрчлийг өмнөх оны аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнтэй харьцуулан үзэхэд 3.1-8.3 дахин өссөн үзүүлэлтэй байна. Энэ нь захиалагч, төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн,

холбогдох албан хаагчдын хариуцлагагүй байдалтай холбоотой байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 19,485.2 сая төгрөгийн зөрчилд 806.3 сая төгрөгийн 58 төлбөрийн акт тогтоож, 17,109.9 сая төгрөгийн 142 албан шаардлага хүргүүлж, 1,210.2 сая төгрөгийн 30 зөвлөмж хүргүүлсэн байна. Залилангийн шинжтэй, ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй 358.8 сая төгрөгийн 2 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 98.6 хувь нь төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрсэн байна

2.2.1 Улсын хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 10,942 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 73.9 хувь буюу 8,082 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. Үүнээс 473,425.0 сая төгрөгийн 7,968 төсөл, арга хэмжээ буюу 98.6 хувь нь төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн бол 14,562.0 сая төгрөгийн 114 төсөл, арга хэмжээ буюу 1.4 хувь нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Хүснэгт №12: Зорилтот түвшинд хүрсэн байдал

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүнд			
		Тоо	Гэрээний дүн	Хүрсэн ТАХ		Хүрээгүй ТАХ	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8
1	Архангай	298	12,383.2	290	11,838.0	8	545.2
2	Баянхонгор	472	24,605.1	470	24,463.9	2	141.2
3	Баян-Өлгий	572	10,783.7	570	10,744.2	2	39.5
4	Булган	411	17,515.2	399	16,368.7	12	1,146.5
5	Говь-Алтай	414	14,589.3	404	13,846.6	10	742.7
6	Говьсүмбэр	86	7,112.1	83	6,313.7	3	798.3
7	Дархан-Уул	252	20,774.8	246	19,019.5	6	1,755.3
8	Дорноговь	180	29,640.5	180	29,640.5	-	-
9	Дорнод	396	29,282.5	393	29,047.3	3	235.2

10	Дундговь	228	10,330.0	223	10,279.6	5	50.4
11	Завхан	579	16,711.1	576	16,346.6	3	364.4
12	Орхон	402	40,953.7	402	40,953.7	-	-
13	Өвөрхангай	283	10,889.9	274	10,312.9	9	577.0
14	Өмнөговь	271	34,139.7	271	34,139.7	-	-
15	Сүхбаатар	196	14,509.3	192	13,076.6	4	1,432.6
16	Сэлэнгэ	262	22,867.3	259	22,628.0	3	239.4
17	Төв	435	37,018.3	431	35,951.4	4	1,066.9
18	Увс	460	12,736.3	460	12,736.3	-	-
19	Ховд	777	36,845.3	763	35,469.7	14	1,375.6
20	Хөвсгөл	534	15,817.0	531	15,545.5	3	271.6
21	Хэнтий	251	17,243.6	248	16,953.0	3	290.6
	Аймгийн дүн	7,759	436,747.9	7,665	425,675.3	94	11,072.6
22	Нийслэл	323	51,239.1	303	47,749.7	20	3,489.4
	Нийт дүн	8,082	487,987.0	7,968	473,425.0	114	14,562.0

(Дэлгэрэнгүйг судалгаа 4-өөс харна уу)

Хүснэгтээс харахад Дорноговь, Орхон, Өмнөговь, Увс аймгуудын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-үүд зорилтод түвшиндээ бүрэн хүрсэн боловч Нийслэл болон Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Ховд аймгууд хамгийн өндөр буюу 9-20 ТАХ зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

Энэ нь 14,562.0 сая төгрөгийн 114 ТАХ бүрэн хэрэгжээгүй байхад санхүүжилтийг олгосон, дутуу, чанаргүй ажлыг хүлээж авсан, хөрөнгийг зориулалтаар нь ашиглаагүй, холбогдох албан тушаалтан ажилдаа хариуцлагагүй хандсан, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэргээс шалтгаалж байна.

Мөн эх үүсвэр бүрэн төвлөрөөгүй, төлөвлөлтийг үндэслэлтэй тооцоогүйгээс батлагдсан төсөв хүрэлцэхгүй болсон, захиалагчаас тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, албан тушаалтнууд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалжээ.

Хүснэгт №13: Зорилтод түвшин харьцуулалт


№	Он	Бүрэн хэрэгжсэн ТАХ-ний тоо	Зорилтод түвшний үр дүнд хүрээгүй ТАХ-ний тоо	Эзлэх хувь
1	2023	7,847	176	2.2
2	2024	8,082	114	1.4

Аймаг, нийслэлийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-нээс зорилтод түвшин, үр дүндээ хүрээгүй 14,562.0 сая төгрөгийн 114 ТАХ байгаа нь өнгөрсөн оноос 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл №7: Иргэдээс авсан санал, асуулгын дүн

6. Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд сэтгэл хангалуун байна уу?

18,649 responses



Аудитын явцад иргэд олон нийтээс авсан Та 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд сэтгэл хангалуун байна уу? гэсэн асуултад нийт иргэдийн 35.7 хувь нь “Тийм”, 36.4 хувь нь “Дунд зэрэг”, 15 хувь нь “Хангалтгүй”, 12.9 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан байна. Эндээс үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд иргэд, олон

нийтийн саналыг тусгаж, зорилтод түвшнийг оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг: Ихтамир, Чулуут, Хангай, Батцэнгэл сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 307.3 сая төгрөгийн 6 ТАХ,
- ✓ Баян-Өлгий аймаг: Аймгийн болон Өлгий, Улаанхус сумын 894.8 сая төгрөгийн 11 ТАХ,
- ✓ Булган аймаг: Бүрэгхангай, Орхон сумын 181.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ,
- ✓ Говь-Алтай аймаг: Аймгийн болон Баян-Уул, Бигэр, Есөнбулаг, Тайшир, Төгрөг, Хөхморьт, Чандмань, Эрдэнэ сумын 64.2 сая төгрөгийн 43 ТАХ,
- ✓ Говьсүмбэр аймаг: Аймгийн болон Сүмбэр сумын 11.9 сая төгрөгийн 5 ТАХ,
- ✓ Дархан-Уул аймаг: Дархан, Хонгор, Шарын гол сумын 3 ТАХ,
- ✓ Дорноговь аймаг: Даланжаргалан, Дэлгэрэх сумын 15.0 сая төгрөгийн 2 ТАХ,
- ✓ Дорнод аймаг: Баянтүмэн сумын 50.0 сая төгрөгийн 1 ТАХ,
- ✓ Өвөрхангай аймаг: Аймгийн болон Богд, Нарийнтээл, Уянга сумын 704.0 сая төгрөгийн 5 ТАХ,
- ✓ Өмнөговь аймаг: Аймгийн болон Баян-Овоо, Даланзадгад, Ханбогд сумын 1,649.6 сая төгрөгийн 13 ТАХ,
- ✓ Төв аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 407.7 сая төгрөгийн 2 ТАХ,
- ✓ Ховд аймаг: Аймгийн болон Алтай, Мянгад сумын 538.5 сая төгрөгийн 3ТАХ,
- ✓ Хөвсгөл аймаг: Аймгийн болон Мөрөн, Тариалан сумын 601.2 сая төгрөгийн 8 ТАХ,
- ✓ Хэнтий аймаг: Баян-Овоо, Галшар сумын 79.7 сая төгрөгийн 3 ТАХ зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

Зорилтод түвшинд хүрээгүй дээрх ТАХ-ний жагсаалтыг (Дэлгэрэнгүйг [хавсралт №2.2.1-ээс харна уу](#))

Шийдвэрлэлт: АНТАГ-аас нийт 4,593.9 сая төгрөгийн зөрчилд 51.1 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 4,301.8 сая төгрөгийн 48 албан шаардлага, 241.0 сая төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

2.2.2 Сангийн яамны Э-тайлангийн системээс үзэхэд улсын хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр 8,998 төсөл, арга хэмжээнд 523,466.5 сая төгрөг зарцуулснаас 46.7 хувь буюу 244,520.1 сая төгрөг нь үндсэн хөрөнгө, 26.2 хувь буюу 136,978.5 сая төгрөг нь барилга байгууламж, 6.3 хувь буюу 33,151.5 сая төгрөг нь их засварт, 4.6 хувь буюу 24,264.1 сая төгрөг нь тоног төхөөрөмжид зарцуулагдсан байна. Харин 16.2 хувь буюу 84,552.3 сая төгрөгийг урсгал зардлын шинжтэй ТАХ-нд зарцуулжээ.

Хүснэгт №14: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний ангилал

(сая төгрөг)

Аймгийн нэр	Нийт гүйцэтгэл	Үүнээс:									
		Барилга байгууламж		Тоног төхөөрөмж		Их засвар		Бусад үндсэн хөрөнгө		Урсгал зардал	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Архангай	14,272.6	2,000.0	14.0	1,453.8	10.2	1,018.7	7.1	9,800.0	68.7	-	-
Баянхонгор	22,215.2	22,215.2	100.0	-	-	-	-	-	-	-	-
Баян-Өлгий	11,639.2	3,048.8	26.2	1,030.2	8.9	793.2	6.8	6,767.1	58.1	-	-
Булган	17,731.6	-	-	-	-	-	-	17,731.6	100.0	-	-
Говь-Алтай	15,597.9	-	-	-	-	-	-	15,518.1	99.5	79.8	0.5
Говьсүмбэр	8,150.6	-	-	-	-	-	-	7,511.0	92.2	639.6	7.8
Дархан-Уул	19,217.4	-	-	-	-	-	-	18,985.2	98.8	232.2	1.2
Дорноговь	42,016.0	-	-	-	-	-	-	-	-	42,016.0	100.0
Дорнод	30,903.4	-	-	-	-	-	-	30,903.4	100.0	-	-
Дундговь	13,885.4	-	-	-	-	-	-	13,885.4	100.0	-	-
Завхан	18,735.9	-	-	-	-	-	-	18,735.9	100.0	-	-
Орхон	57,443.5	46,950.2	81.7	4,942.8	8.6	-	-	40.1	0.1	5,510.4	9.6
Өвөрхангай	14,386.9	-	-	-	-	-	-	14,386.9	100.0	-	-
Өмнөговь	36,074.3	-	-	-	-	-	-	-	-	36,074.3	100.0
Сүхбаатар	16,781.2	4,967.0	29.6	1,294.8	7.7	1,052.3	6.3	9,467.1	56.4	-	-

Сэлэнгэ	25,729.9	14,102.6	54.8	3,809.4	14.8	2,891.8	11.2	4,926.1	19.1	-	-
Төв	25,235.9	5,252.0	20.8	1,526.9	6.1	9,063.2	35.9	9,393.8	37.2	-	-
Увс	13,431.2	-	-	-	-	-	-	13,431.2	100.0	-	-
Ховд	40,139.5	18,136.4	45.2	3,763.8	9.4	9,130.0	22.7	9,109.3	22.7	-	-
Хөвсгөл	17,806.9	-	-	-	-	-	-	17,806.9	100.0	-	-
Хэнтий	17,518.9	-	-	-	-	-	-	17,518.9	100.0	-	-
Нийслэл	44,553.1	20,306.4	45.6	6,442.4	14.5	9,202.2	20.7	8,602.1	19.3	-	-
Нийт дүн	523,466.5	136,978.5		24,264.1		33,151.5		244,520.1		84,552.3	
Хувь	100.0	26.2		4.6		6.3		46.7		16.2	

(Эх сурвалж: Сангийн яам Э-тайлан системээс)

Сангийн яамны Э-тайлангийн цахим системд Ховд аймгийн Дуут сумын ОНХС-ийн дансанд төвлөрсөн 6.4 сая төгрөгийн андуурсан орлогын гүйлгээг залруулаагүй, Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын ОНХС-ийн данснаас хоршоог хөгжүүлэх сангийн 1.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээг андуурч хийсэн зэргээс шалтгаалж аймаг, нийслэлийн ОНХС-ийн орлого, зарлагын нийт дүн 5.2 сая төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

Хэрэгжүүлсэн нийт 523,461.3 сая төгрөгийн 8,998 төсөл, арга хэмжээний 98.0 хувийг Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 4.2-т заасан чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлсэн бол 2.0 хувийг журамд заагаагүй ТАХ-г санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

Дүрслэл №8: ОНХС-ийн зарцуулалт (чиг үүргээр)

(сая төгрөг)



(Дэлгэрэнгүйг судалгаа 8, 9-өөс харна уу)

Графикаас үзэхэд хэрэгжүүлсэн нийт ТАХ-ний 24.6 хувийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, соёл, боловсролыг дэмжих, хөгжүүлэх, 21.0 хувийг орон нутгийн хөгжлийг дэмжсэн дэд бүтцийг сайжруулах, 24.5 хувийг эрүүл аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах, 27.9 хувийг бусад чиг үүргийг сайжруулахад чиглэсэн нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх гэсэн ОНХС-ийн үндсэн зорилгыг хангаж, орон нутгийн хөгжилд хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй ажил болсон байна.

Төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрсэн орон нутгийн хөгжилд бодит хувь нэмрээ өгсөн өндөр үр нөлөөтэй **сайн жишээ**-нээс дурдвал:

Аймгуудын сайн жишээний (*Дэлгэрэнгүйг [хавсралт №-2.2.2](#)-оос харна уу*)

Баянхонгор аймаг:

- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр “Байгалийн сэргэн ургалтыг дэмжих зорилгоор Заган ойг хашиж хамгаалах” ТАХ-нд 172.9 сая төгрөг, “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төслөөс 102.2 сая төгрөг, нийт 275.1 сая төгрөгөөр Зармангийн говийн бүсэд хамаарах Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нийт 300 га талбайг хашиж, заган ойг сэргээх, ургалтыг дэмжих ажил хийж, мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан хүлээн авсан байна.

Дорноговь аймаг:

- ✓ Монгол Улсын 330 сумаас анх удаа Замын-Үүд суманд “Цусны салбар банк буюу цусны төв” нээгдэж цус алдсан, цус багадалттай хүнд түргэн, шуурхай цус бэлтгэн сэлбэлт хийх, цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох шинжилгээ хийх зэрэг ажлыг хийснээр сумын Нэгдсэн эмнэлгийн цусны салбар төвийн тусламж үйлчилгээ үзүүлэх чанар хүртээмж нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндэд чиглэсэн үр нөлөөтэй томоохон ажлын нэг болж чадсан байна.

АНТАГ-аас ирүүлсэн судалгаа, тайлангаас үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрсэн сайн талтай ч зарим аймгуудад орон нутгийн хөгжилд үр нөлөөгүй, урсгал зардлын шинжтэй арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан зөрчил гарсаар байна. Үүнд:

Архангай аймгийн хэмжээнд 4,366.0 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн хэмжээнд 1,535.7 сая төгрөг, Баянхонгор аймгийн хэмжээнд 5,139.8 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн хэмжээнд 1,377.5 сая төгрөг, Дархан-Уул аймгийн хэмжээнд 3,228.6 сая төгрөг, Дундговь аймгийн хэмжээнд 1,388.1 сая төгрөг, Завхан аймгийн хэмжээнд 9,918.5 сая төгрөг, Орхон аймгийн хэмжээнд 6,416.3 сая төгрөг, Өвөрхангай аймгийн хэмжээнд 1,627.3 сая төгрөг, Сүхбаатар аймгийн хэмжээнд 1,512.8 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн хэмжээнд 3,174.5 сая төгрөг, Хөвсгөл аймгийн хэмжээнд 4,074.0 сая төгрөг, Хэнтий аймгийн хэмжээнд 723.6 сая, Нийслэлийн хөрөнгөд бүртгэх боломжгүй 6,071.7 сая төгрөгийг урсгал зардлын шинжтэй арга хэмжээний зардалд төлөвлөж, зарцуулжээ.

Мөн зарим төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй, хийгдсэн ажлууд дутуу, чанаргүй хийгдсэн, холбогдох албан тушаалтан ажилдаа хариуцлагагүй хандсан, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу хийгдээгүй, ашиглалтын явцад эвдэрсэн, чанар байдал нь муудсан, хөрөнгийг ашиглаагүй зэрэг зөрчил нь төсөл арга хэмжээний үр дүн, үр нөлөөг бууруулж байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Урсгал зардлын шинжтэй арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан зөрчил:

- ✓ Завхан аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 9,918.5 сая төгрөгийн урсгал зардлын шинжтэй, нэг удаагийн арга хэмжээний зардалд хэт ихээр төлөвлөж, зарцуулж байгаа нь тус сангийн хөрөнгийн үр нөлөөг бууруулж, мөн чанарыг алдагдуулж байна. /Аймгийн ОНХС, Ургамал, Алдархаан, Баянхайрхан, Их-Уул, Нөмрөг, Отгон, Сонгино, Цагаанчулуут, Завханмандал, Сантмаргаз, Баянтэс, Асгат, Тосонцэнгэл, Дөрвөлжин, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Яруу, Улиастай, Тэс, Түдэвтэй/
- ✓ Завхан аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр өгөхүйц төсөл арга хэмжээг цөөн хэрэгжүүлжээ. Иймд орон нутагт үр өгөөжтэй, томоохон хөрөнгө оруулалтын ажлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. /Аймгийн ОНХС, Ургамал, Алдархаан, Баянхайрхан, Их-Уул, Нөмрөг, Отгон, Сонгино, Цагаанчулуут, Завханмандал, Сантмаргаз, Баянтэс, Асгат, Тосонцэнгэл, Дөрвөлжин, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Шилүүстэй, Яруу, Улиастай, Тэс, Тэлмэн, Түдэвтэй/

- ✓ Завхан аймгийн Баянхайрхан, Ургамал суманд 166.2 сая төгрөгийн ОНХС-ийн хөрөнгийг хэт жижиглэж, тухайн байгууллагын төсөвт тусгаж хэрэгжүүлэх боломжтой урсгал болон хөрөнгийн зардалд төлөвлөж, зарцуулсан. /өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжээгүй/.

Ашиглалттай холбоотой зөрчил:

- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Шуурхай удирдлагын төв”-ийг байгуулсан боловч тус дэд төвд эмнэлэг, онцгой байдлын газрын албан хаагчид ажиллаагүй бүрэн ашиглалтгүй байна.
- ✓ Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд НОНХС-аар БЗД-д хийгдсэн 399.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 ТАХ, СБД, СХД, БЗД, ХУД-т хийгдсэн 1,422.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ буюу тохижилт, явган зам, тоосжилт бууруулах зэрэг нь ашиглалтын явцад эвдэлсэн, чанар байдал нь муудсан.

Гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй:

- ✓ Баянхонгор аймгийн болон Богд, Баянбулаг, Гурванбулаг, Өлзийт сумын 1,355.7 сая төгрөгийн 6 ТАХ,

Зураг төсвийн дагуу ажлуудыг хийгээгүй:

- ✓ Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын "Баян-Өндөр сумын 0.4кВ-ын шугамын өргөтөл, засварын шинэчлэл"-ийн ажлыг 85.1 сая төгрөгийн 1 ТАХ,
- ✓ Ховд аймгийн болон Цэцэг сумын 217.4 сая төгрөгийн 3 ТАХ,

Хийгдсэн ажлууд дутуу:

- ✓ Баянхонгор аймгийн болон Баянлиг, Шинэжинст, Баянхонгор сумын 136.5 сая төгрөгийн 7 ТАХ,

Чанаргүй хийгдсэн:

- ✓ Баянхонгор аймгийн болон Бууцагаан, Өлзийт сумын 244.0 сая төгрөгийн 3 ТАХ,

Ажлын хэсэгт мэргэжлийн хүн байгаагүйн улмаас чанаргүй ажил хүлээж авсан:

- ✓ Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын 85.1 сая төгрөгийн 90 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна фасад засвар болон гадна тохижилтын ажил болох 1 ТАХ,

Холбогдох албан тушаалтан ажилдаа хариуцлагагүй хандсан:

- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 673.7 сая төгрөгийн хуучнаар Жаргалан паркийн газар шорооны ажил болон төв хаалганы төмөр бетон хийцийг гүйцэтгэсэн ба Баянхонгор аймгийн Засаг дарга, ХОБХТХ-ийн дарга, мэргэжилтэн, ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга, зураг төсөв зохиогч болон гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн дарга нар 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хуралдаж, дээрх төсөл арга хэмжээнд батлагдсан санхүүжилтийг Оготнотой булагт хүүхдийн тоглоомын цогцолбор байгуулахад зарцуулах шийдвэрийг гаргасан ба ажил гүйцэтгэх гэрээг шинэчлэн байгуулаагүй.
- ✓ Баянхонгор аймгийн "Шинэжинст сумын Залаажинстийн цагаан ямааны цөм сүргийг сайжруулах" 20.0 сая төгрөгийн ажлыг иргэдээс санал аваагүй байхад баталж, "Залаа зөвлөл" НҮТББ гүйцэтгэсэн бөгөөд судалгааг 2010-2021 оны мэдээллийг ашигласан нь 2022-2023 оны мэдээллийг хамруулаагүй, судалгааны үр дүнд ямар санаа санал дэвшүүлсэн, түүнийг хэрэгжүүлж үр дүнг гаргасан эсэх нь тодорхойгүй байна.
- ✓ Говь-Алтай аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэгдсэн өвс тэжээлийг малчдад 4.5 сая төгрөгөөр үнэ бууруулан олгосон байна.

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгээгүй:

- ✓ Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга "Сумын төвийн камержуулалт" ажлын гэрээнд хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлд нийт 11.9 сая төгрөгийн дрон, нарны толь, бусад тоног төхөөрөмжийг олгосон.
- ✓ Сэлэнгэ аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд бүртгээгүй, нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын болон дээврийн засварын 3 төсөл, арга хэмжээг 751.6 сая төгрөгөөр тусгаж, хэрэгжүүлсэн байна.

Хуулийн байгууллагад шилжүүлсэн:

- ✓ Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр Цаг уурын станцын барилгыг

шинээр барьж ашиглалтад оруулах 97.8 сая төгрөгийн гэрээг 2023 онд “Нью бест хаус” ХХК байгуулж урьдчилгаа төлбөрт 53.7 сая төгрөгийг олгосон. 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон боловч одоо хүртэл төлбөрийн актыг барагдуулаагүй, төсвийн захирагч нь ажлаас чөлөөлөгдсөн, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлсэн бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 02-ны байдлаар асуудал шийдэгдээгүй байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас нийт 4,786.2 сая төгрөгийн зөрчилд 11.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 2,898.6 сая төгрөгийн 24 албан шаардлага, 1,821.9 сая төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Харин 53.8 сая төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж байгаа ч аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд ТАХ-ний үр дүн, үр өгөөжийг урьдчилан тооцохгүйгээр төсвийн байгууллагын урсгал зардлын шинжтэй, богино хугацааны хэрэгцээ шаардлагыг хангасан төсөл арга хэмжээнд төлөвлөн зарцуулж байгаа нь сангийн хөрөнгийн үр дүн, үр өгөөжийг бууруулж, төлөвлөсөн зорилтод түвшиндээ хүрэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн 98.8 хувийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна

2.3.1 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн 98.8 хувь буюу 481,224.5 сая төгрөгийн 7,986 төсөл арга хэмжээг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа бол 0.9 хувь буюу 5,482.2 сая төгрөгийн 73 төсөл арга хэмжээний хөрөнгө ашиглалтгүй, 0.3 хувь нь буюу 1,280.3 сая төгрөгийн 23 ТАХ зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Хүснэгт №15: Хөрөнгийн ашиглалтын байдал

(сая төгрөг)

Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр,		ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт					
	тоо	гэрээний дүн	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй ТАХ		Зориулалтын бус ашиглаж буй ТАХ		Огт ашиглаагүй ТАХ	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Архангай	298	12,383.2	293	12,091.3	3	173.8	2	118.1
Баянхонгор	472	24,605.1	459	24,149.6	1	57.9	12	397.6
Баян-Өлгий	572	10,783.7	564	10,663.5	1	19.5	7	100.7
Булган	411	17,515.2	410	17,507.2	-	-	1	8.0
Говь-Алтай	414	14,589.3	403	13,667.1	-	-	11	922.2
Говьсүмбэр	86	7,112.1	80	6,348.5	6	763.6	-	-
Дархан-Уул	252	20,774.8	247	20,573.9	1	16.0	4	185.0
Дорноговь	180	29,640.5	179	29,622.5	1	17.9	-	-
Дорнод	396	29,282.5	394	29,097.3	-	-	2	185.2
Дундговь	228	10,330.0	225	10,284.6	1	13.0	2	32.4
Завхан	579	16,711.1	576	16,346.6	1	3.8	2	360.6
Орхон	402	40,953.7	402	40,953.7	-	-	-	-
Өвөрхангай	283	10,889.9	277	10,744.4	2	31.9	4	113.6
Өмнөговь	271	34,139.7	271	34,139.7	-	-	-	-
Сүхбаатар	196	14,509.3	196	14,509.3	-	-	-	-
Сэлэнгэ	262	22,867.3	259	22,624.5	-	-	3	242.8
Төв	435	37,018.3	429	35,724.5	1	99.9	5	1,193.9
Увс	460	12,736.3	456	12,695.3	-	-	4	41.0
Ховд	777	36,845.3	772	36,762.3	5	83.0	-	-
Хөвсгөл	534	15,817.0	525	14,599.4	-	-	9	1,217.6

Хэнтий	251	17,243.6	246	16,880.1	-	-	5	363.5
Аймгийн дүн	7,759	436,747.9	7,663	429,985.4	23	1,280.3	73	5,482.2
Нийслэл	323	51,239.1	323	51,239.1				
Нийт дүн	8,082	487,987.0	7,986	481,224.5	23	1,280.3	73	5,482.2

Эх сурвалж: АНТАГ-ын аудитын явцад хийгдсэн судалгаа (Дэлгэрэнгүйг судалгаа 4-өөс харна уу)

Бүрэн хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээний 0.9 хувь буюу 5,482.2 сая төгрөгийн 73 төсөл арга хэмжээний хөрөнгө ашиглалтын явцад эвдэрч, гэмтсэн, мэргэжлийн боловсон хүчингүй, чанаргүй хийгдсэн зэргээс шалтгаалж ашиглалтгүй байна.

Аудитаар зэрэгцүүлэлтийн шинжилгээний арга ашиглан ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалтыг өнгөрсөн онтой харьцуулбал:


Хүснэгт №16: Хөрөнгийн ашиглалтын байдал зэрэгцүүлэлт

(сая төгрөг)

Хамрагдах он	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр,		Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй АХ		Эзлэх хувь	Огт ашиглаагүй ТАХ		Эзлэх хувь
	тоо	дүн	тоо	дүн		тоо	дүн	
2023 он	7,847	389,155.8	7,472	366,584.6	95.2	201	22,463.8	2.6
2024 он	8,082	487,987.0	7,986	481,224.5	98.8	73	5,482.3	0.9

Хүснэгтээс харахад ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй байдал 2024 онд 98.8 хувь болж 3.6 хувиар өссөн, огт ашиглалтгүй хөрөнгө 0.9 хувь болж 1.7 хувиар буурсан нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт сайжирсан болохыг харуулж байна.

Дүрслэл №9: Ашиглагч байгууллагын чанарын үнэлгээ



Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт 8,082 төсөл, арга хэмжээний чанарт өгөх үнэлгээ ашиглагч байгууллагын судалгаанаас үзэхэд 7,402 ТАХ буюу 91.6 хувь нь ашиглалт “Сайн”, 593 буюу 7.3 хувь нь ашиглалт “Дунд”, 87 буюу 1.1 хувь нь ашиглалт “Муу” гэж үнэлсэн байгаа нь хөрөнгийн ашиглалт сайн байгааг харуулж байна.

Харин 18,628 иргэнээс авсан “2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар та ямар үнэлгээ өгөх вэ?” гэсэн санал асуулгаар 5,718 иргэн буюу 30.7 хувь нь “Хангалттай”, 7488 иргэн буюу 40.2 хувь нь “Дунд”, 2794 иргэн буюу 15 хувь нь “Хангалтгүй”, 14.1 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан байна.

Аудитаар ашиглалтгүй хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Зориулалт бусаар ашигласан ТАХ:

- ✓ Архангай аймаг 173.8 сая төгрөгийн 3, Баянхонгор аймаг 57.9 сая төгрөгийн 1, Баян-Өлгий аймаг 19.5 сая төгрөгийн 1, Говьсүмбэр аймаг 763.6 сая төгрөгийн 6, Дархан-Уул аймаг 16.0 сая төгрөгийн 1, Дорноговь аймаг 17.9 сая төгрөгийн 1, Дундговь аймаг 13.0 сая төгрөгийн 1, Завхан аймаг 3.8 сая төгрөгийн 1, Өвөрхангай аймаг 31.9 сая төгрөгийн 2, Төв аймаг 99.9 сая төгрөгийн 1, Ховд аймаг 83.0 сая төгрөгийн 5 хөрөнгийг зориулалт бусаар ашигласан байна. (Дэлгэрэнгүйг [хавсралт №-2.3.1А](#)-ээс харна уу)

Огт ашиглаагүй ТАХ:

- ✓ Архангай аймаг 118.1 сая төгрөгийн 2, Баянхонгор аймаг 397.6 сая төгрөгийн 12, Баян-Өлгий аймаг 100.7 сая төгрөгийн , Булган аймаг 8.0 сая төгрөгийн 1, Говь-Алтай аймаг 922.1 сая төгрөгийн 11, Дархан-Уул аймаг 185.0 сая төгрөгийн 4, Дорнод аймаг 185.2 сая төгрөгийн 2, Дундговь аймаг 32.4 сая төгрөгийн 2, Завхан аймаг 360.6 сая төгрөгийн 2, Өвөрхангай аймаг 113.6 сая төгрөгийн 4, Сэлэнгэ аймаг 242.8 сая төгрөгийн 3, Төв аймаг 1,193.9 сая төгрөгийн 5, Увс аймаг 41.0 сая төгрөгийн 4, Хөвсгөл аймаг 1,217.6 сая төгрөгийн 9, Хэнтий аймаг 363.5 сая төгрөгийн 5 хөрөнгө ашиглалтгүй байна. (*Дэлгэрэнгүйг хавсралт №2.3.1Б-ээс харна уу*)

Шийдвэрлэлт: АНТАГ-аас нийт 3,723.2 сая төгрөгийн зөрчилд алдаа, зөрчлийг давтан гаргуулахгүй байх, зөрчил арилгуулах 1,319.9 сая төгрөгийн 21 албан шаардлага, 2,403.3 сая төгрөгийн 14 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дээрх зөрчлөөс харахад захиалагч талаас төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлага, хүртэх үр өгөөжийг тооцоолоогүй, гүйцэтгэгч нар ажил, үйлчилгээг чанаргүй гүйцэтгэснээс зарим аймагт ашиглалтгүй хөрөнгүүд бий болж, хариуцсан байгууллага хяналтаа сул хэрэгжүүлснээс зориулалт бусаар ашиглах зэрэг зөрчлүүд эзэлж байна.

2.3.2 “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12-т “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасан. Гэтэл хариуцагч байгууллагын хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүйгээс 3,967.9 сая төгрөгийн 40 ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгө эзэнгүйдэх, эвдэрч муудах, гэмтэх, хулгайд алдагдах, дутагдах, бусдад ашиглуулах зэрэг зөрчил илэрч байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт:

- ✓ Говьсүмбэр аймаг. Баянтал сумын спорт заалны суурийн ажлын суурь хазайсан, завсар гарсан, Шивээговь сумын хөл бөмбөгийн талбайн хашааны тор эвдэрсэн,
- ✓ Дархан-Уул аймаг: Шарын гол сумын “нэг маягийн сагсан бөмбөгийн талбай, тоглоомын талбайн тохижилтын ажил”-ын 1 сандал, 5 хогийн сав эвдэрсэн, сагсны талбайн будаг халцарсан, Шарын гол сумын “Сумын доторх авто замын хяналтын камерын засвар, шинэчлэл” ажлын хүрээнд 6 камер ажиллахгүй, Орхон сумын өвсний агуулах засварлах ажлын хүрээнд хийсэн өвсний агуулахын том хаалганы бэхэлгээ, 2 талын амлагаа хийгдээгүй, дээврээс ус алдсан, Орхон сумын Тосгон Богчийн дэв, Дэлгэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтын ажлын хүрээнд хийсэн сүлжээний төхөөрөмж бүрэн ажиллахгүй,
- ✓ Дундговь аймаг: Сайнцагаан сумын “Төвийн багуудын танилцуулга, гэрэлт самбарын байгууламж барих ажил” зарим хэсэг нь унасан, 3.5 км улсын чанартай авто замын гэрэлтүүлгийн шон эвдэрсэн, зарим гэрлийн толгойн хүрээ эвдэрсэн
- ✓ Өмнөговь аймаг: Даланзадгад сумын “Өглөөний гудамж, 2-р багт хийгдсэн автомашингүй гудамж, 1 дүгээр сургуулийн хөгжмийн кабинетын тоног төхөөрөмж хадгалалт хамгаалалт алдагдсан, Ханбогд сумын “Цагаан хад суурьшлын бүсэд ашиглах 50 ковш худалдан авах” ТАХ-ны тээврийн хэрэгслийн гэрчилгээ аваагүй, эд хөрөнгийн өмчлөгч тодорхойгүй, Цогтцэций сумын “Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах (Уурхайчин)”, “Өгөөмөр талбайг шинэчлэн тохижуулах” ажлын хадгалалт хамгаалалт алдагдсан,
- ✓ Ховд аймаг: ЭМТ-н барилгын засварын ажил чанаргүй хийгдсэн, лабораторын тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гематологийн аппарат эвдрэлтэй, Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн камержуулалт, 1 дүгээр сургуулийн спорт заалны их засвар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуут дохио, Эрдэнэбүрэн, Цэцэг сумын гэрэлтүүлэг, Жаргалант сумын орон сууцны тохижилт, Манхан сумын хашаа татах ажил, Хан алтайн дуулал цогцолборын гадна их засварын ажлын хадгалалт, хамгаалалт алдагдсан,

- ✓ Хөвсгөл аймаг: "Төв саадын тохижилт" лед гэрэл, усан оргилуур, "13 дугаар багийн Шинээр тавигдсан засмал зам дагуу гэрэлтүүлэг эвдэрч, шатсан
- ✓ Нийслэл: Түүвэрт хамрагдсан 20 ТАХ-нд хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс нийлүүлсэн тоног төхөөрөмж эвдэрч, алга болж бүрэн ашиглах боломжгүй болсон.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 4,019.8 сая төгрөгийн зөрчилд 353.5 сая төгрөгийн 11 албан шаардлага, 3,666.3 сая төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Дээрх байдлаас харахад ОНХС-аар бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт хангалтгүйгээс эд хөрөнгө эвдэрч, гэмтэх нөхцөл байдал үүссэн тул холбогдох байгууллагуудад зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн байна.



БҮЛЭГ 3: ОНХС-ИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ БОЛОН УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД ИЛ ТОД, ҮНЭН ЗӨВ МЭДЭЭЛЭХ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

3.1 ОНХС-ийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн буюу нийт хэрэгжүүлсэн ТАХ-ний 8.1-18.3 хувьд нь хяналт тавьж ажилласан байна

3.1.1 Нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 81.7 хувьд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, 91.9 хувьд дотоод аудитын нэгжээс хяналт хэрэгжүүлээгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.2.2, 9.4, 9.5-т ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон тус журмын хэрэгжилтэд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо, иргэний нийгмийн байгууллагууд, дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллага нь хяналт тавьж ажиллахаар заасан.

Дүрслэл №10: ОНХС-ийн ТАХ-ны хяналтын тоо



Тус журмын хүрээнд 2024 онд гүйцэтгэсэн 8,998 ТАХ-нд хэрэгжүүлсэн хяналтыг АНТАГ-аас ирүүлсэн тайлан, судалгааг авч нэгтгэн үзэхэд шат, шатны ИТХ-аас 1,658, дотоод аудитын нэгжээс 727 төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлжээ. Энэ нь нийт төсөл арга хэмжээнд тавих хяналтын тоо өмнөх оноос ИТХ-ынх 34.3 хувиар,

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрынх 21.4 хувиар тус тус буурсан үзүүлэлтэй байна.

Хүснэгт №17: ОНХС-ийн хяналт аймаг, нийслэлээр

№	Аймаг, сумын нэр	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл	ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасан хяналтыг хэрэгжүүлсэн эсэх					
			ИТХ			Дотоод аудит		
			Хяналт хэрэгжүүлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн тоо	тийм	үгүй	Хяналт хэрэгжүүлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн тоо	тийм	Үгүй
1	2	3	4	5	6	7	8	9
1	Архангай	324	14	162	162	3	43	281
2	Баянхонгор	539	12	12	527	8	8	531
3	Баян-Өлгий	654	3	90	564	0	0	654
4	Булган	438	9	9	429	5	33	405
5	Говь-Алтай	479	10	188	291	0	0	479
6	Говьсүмбэр	104	3	45	59	4	90	14
7	Дархан-Уул	276	3	111	165	0	0	276
8	Дорноговь	200	13	133	67	0	0	200
9	Дорнод	432	10	10	422	4	4	428
10	Дундговь	251	16	16	235	3	3	248
11	Завхан	606	18	385	221	1	1	605
12	Орхон	486	2	2	484	2	2	484
13	Өвөрхангай	326	20	0	326	3	3	323
14	Өмнөговь	289	7	111	178	0	0	289
15	Сүхбаатар	253	14	14	239	14	0	253
16	Сэлэнгэ	302	15	133	169	9	141	161
17	Төв	474	14	14	460	28	28	446
18	Увс	501	9	9	492	1	1	500
19	Ховд	836	11	11	825	7	7	829
20	Хөвсгөл	566	19	19	547	16	16	550
21	Хэнтий	301	4	4	297	0	0	301
Аймгийн дүн		8,637	226	1,478	7,159	108	380	8257
22	Нийслэл	361	0	0	361	8	347	14

Нийт дүн	8,998	226	1,478	7,520	116	727	8,271
----------	-------	-----	-------	-------	-----	-----	-------

Эх сурвалж: АНТАГ-ын аудитын явцад хийгдсэн судалгаа (Дэлгэрэнгүйг судалгаа 5-аас харна уу)

Дээрх хүснэгтээс харахад улсын хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагаанд аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ болон санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас тавих хяналт, хамрах хүрээ хангалтгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг: Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 33 төсөл арга хэмжээнд аймгийн ИТХ-ын хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй мөн Санхүүгийн хяналт аудитын газраас аймаг, сумын ОНХС-ийн 2024 оны хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 324 ТАХ-ний 86.7 хувь буюу 281 ТАХ-нд хяналт тавьж ажиллаагүй байна. Ихтамир сум 20, Чулуут сум 14, Өндөр-Улаан сум 26, Эрдэнэмандал сум 16, Өлзийт сум 10, Хотонт сум 11, Цэнхэр сум 10, Булган сум 12, Эрдэнэбулган сум 10 ТАХ-нд сумын ИТХ-аас нийт 129 ТАХ-нд хяналт хэрэгжүүлээгүй байна.
- ✓ Баян-Өлгий аймаг: Алтай, Цэнгэл, Улаанхус сумдын ИТХ-аас бусад сум болон аймгийн ИТХ хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй мөн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас 2024 онд аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд хяналт тавьж ажиллаагүй байна.
- ✓ Баянхонгор аймаг: Сумдын ИТХ-аар хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулаагүй, Эрдэнэцогт, Бууцагаан, Баян-Өндөр, Галуут, Баянбулаг, Хүрээмарал, Богд, Баян-Овоо сумдын ИТХ-ын хяналтын хороо ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажиллаагүй байна. Мөн аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас аймаг болон Баянлиг, Хүрээмарал, Баянговь, Жинст, Баян-Овоо, Бөмбөгөр, Жаргалант зэрэг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн өвс, тэжээлийн нөөц бэлтгэх төсөл арга хэмжээнд хяналт хийж, бусад төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажиллаагүй байна.
- ✓ Булган аймаг: Аймгийн болон Баяннуур, Бугат, Булган, Дашинчилэн, Могод, Рашаант, Хангал, Хутаг-Өндөр, Хялганат сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд огт хяналт хийгээгүй байна. Мөн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгээгүй байлаа.
- ✓ Говь-Алтай аймаг: Аймгийн ИТХ 72, Алтай, Бигэр, Бугат, Дарви, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Халиун, Цогт, Цээл, Чандмана, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумдын ИТХ-ын хяналтын хороо 270, нийт 342 төсөл арга хэмжээнд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна. Мөн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас хяналт хэрэгжүүлээгүй байна.
- ✓ Говьсүмбэр аймаг: Баянтал сумын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй.
- ✓ Дархан-Уул аймаг: Дархан сумын ИТХ болон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
- ✓ Дорноговь аймаг: Тайлант онд Хөвсгөл сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 5 ТАХ, Дэлгэрэх сумын 15 ТАХ-д сумын ИТХ-аас хяналтыг огт хэрэгжүүлээгүй.
- ✓ Дорнод аймаг: Аймгийн ИТХ хурал болон Хөлөнбуйр, Баянтүмэн, Матад, Цагаан-Овоо сумдын ИТХ нь ОНХС-ийн 2024 оны хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд хууль, журамд заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Мөн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар аймгийн болон Чойбалсан, Баянтүмэн, Дашбалбар сумдаас бусад сумдын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавиагүй.
- ✓ Завхан аймаг: Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Өвөрхангай аймаг: Аймгийн ИТХ болон Арвайхээр, Баруунбаян-Улаан, Бат-Өлзий, Баянгол, Баян-Өндөр, Богд, Гучин-Ус, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Өлзийт, Сант, Тарагт, Төгрөг, Уянга, Хайрхандулаан, Хархорин, Хужирт сумын ИТХ-аас ОНХС-ийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавиагүй;
- ✓ Сүхбаатар аймаг: Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй;

- ✓ Сэлэнгэ аймаг: Аймгийн болон Мандал, Сайхан сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын зүгээс ОНХС-аар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд огт хяналт хийгээгүй, Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Орхонтуул, Сант, Хушаат сумдын ИТХ-ын дэргэдэх хороо нь хяналтыг дутуу хэрэгжүүлсэн;
- ✓ Увс аймаг: Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас аймаг, сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй;
- ✓ Ховд аймаг: Буянт, Зэрэг, Мянгад, Цэцэг, Эрдэнэбүрэн сумдын ИТХ-аас ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй;
- ✓ Хөвсгөл аймаг: Арбулаг, Бүрэнтогтох, Галт, Цэцэрлэг, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын ИТХ хяналтыг чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй;
- ✓ Хэнтий аймаг: Аймгийн ИТХ болон Батширээт, Баян-Адарга, Биндэр, Бэрх, Галшар, Гурванбаян, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Норовлин, Өлзийт, Өмнөдэлгэр, Хэрлэн, Хэрлэнбаян-Улаан, Цэнхэрмандал сумдын ИТХ-аас ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй;
- ✓ Нийслэл: Нийслэл, дүүргийн ИТХ-аас ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавиагүй бол Сүхбаатар, Хан-Уул дүүргийн санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй;

ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ИТХ болон дотоод аудитын нэгж чиг үүргээ хэрэгжүүлэхгүйгээс төсөв, санхүүгийн сахилга бат алдагдах, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж үр ашиггүй зардал гаргах, гүйцэтгэлийн чанар муудах, бүртгэл тайланд тусгахгүй байх, төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй зэрэг алдаа зөрчил жил бүр давтан гарч байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 15.2 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчил давтан гаргахгүй байх 7 албан шаардлага хүргүүлж, 15.2 сая төгрөгийн 59 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.1.2 "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.3.3, 3.3.5, 3.4.3-т заасны дагуу ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар нь хяналт тавьж, цаашид авах хэмжээг зохион байгуулан ажиллахаар заасан.

Дүрслэл №11: Захиалагчийн хяналт



(Дэлгэрэнгүйг судалгаа 5-аас харна уу)

Улсын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 523,461.3 сая төгрөгийн 8,998 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Үүнээс 433,412.5 сая төгрөгийн 6,522 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн бол 90,048.9 сая төгрөгийн 2,476 төсөл, арга хэмжээ буюу 27.5 хувьд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн Өндөр-Улаан сум 374.0 сая төгрөгийн 26, Эрдэнэмандал сум 156.2 сая төгрөгийн 4, Өгийнуур сум 269.9 сая төгрөгийн 6, Хашаат сумын 362.7 сая төгрөгийн 17, Төвшрүүлэх сумын 849.0 сая төгрөгийн 25, Цахир сумын 109.9 сая төгрөгийн 8, нийт 2,121.7 сая төгрөгийн 86 ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;

- ✓ Баян-Өлгий аймгийн Буян сум 117.7 сая төгрөгийн 19, Ногооннуур сум 400.3 сая төгрөгийн 41, Улаанхус сум 107.0 сая төгрөгийн 13, Цэнгэл сум 225.8 сая төгрөгийн 11, нийт 850.8 сая төгрөгийн 84 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Баянхонгор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 7,182.9 сая төгрөгийн 63, Баянхонгор, Галуут, Баян-Овоо, Эрдэнэцогт, Бууцагаан, Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Гурванбулаг, Жаргалант, Заг, Баацагаан, Бөмбөгөр, Өлзийт, Хүрээмарал, Баянбулаг, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан сумд 10,996.5 сая төгрөгийн 433, нийт 18,179.5 сая төгрөгийн 496 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Булган аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2,854.4 сая төгрөгийн 7, Бүрэгхангай, Дашинчилэн, Орхон, Сайхан, Тэшиг, Хангал, Хялганат сумд 2,348.4 сая төгрөгийн 46, нийт 5,202.8 сая төгрөгийн 53 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Говь-Алтай аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 412.1 сая төгрөгийн 18, Алтай, Баян-Уул, Бигэр, Дарви, Дэлгэр, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Эрдэнэ, Есөнбулаг сумд 3,402.6 сая төгрөгийн 200, нийт 3,814.8 сая төгрөгийн 218 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Говьсүмбэр аймгийн ОНХС-аар хэрэгжүүлсэн 146.9 сая төгрөгийн 1, Шивээговь сум 111.3 сая төгрөгийн 1, Баянтал сум 103.1 сая төгрөгийн 3, нийт 361.3 сая төгрөгийн 5 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, мөн зарим барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавихдаа ил, далд ажлын актыг баталгаажуулаагүй байв;
- ✓ Дорноговь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 83.5 сая төгрөгийн 6, Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Мандах, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд сумд 96.3 сая төгрөгийн 39, нийт 179.8 сая төгрөгийн 45 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Дорнод аймаг болон 14 сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Дундговь аймгийн Баянжаргалан, , Дэлгэрхангай, Луус, Өлзийт, Өндөршил, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумд нийт 1,443.8 сая төгрөгийн 19 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Завхан аймгийн Алдархаан, Асгат, Баянхайрхан, Завханмандал, Дөрвөлжин, Сантмаргаз, Тосонцэнгэл, Түдэвтэй, Ургамал, Улиастай, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан, Яруу сумд нийт 7,504.6 сая төгрөгийн 314 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Нийслэлийн Баянзүрх дүүрэг 596.3 сая төгрөгийн 4, Багахангай дүүрэг 17.1 сая төгрөгийн 2, Сонгинохайрхан дүүрэг 25.5 сая төгрөгийн 2, нийт 638.9 сая төгрөгийн 8 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Өвөрхангай аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 599.3 сая төгрөгийн 3, Бат-Өлзий, Баянгол, Баян-Өндөр, Богд, Бүрд, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Өлзийт, Тарагт, Төгрөг, Уянга, Хархорин, Хужирт сумд 4,312.4 сая төгрөгийн 154, нийт 4,911.7 сая төгрөгийн 157 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Өмнөговь аймгийн Баяндалай, Баян-Овоо, Булган, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Манлай, Ноён, Номгон, Сэврэй, Ханбогд, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо, Цогтцэций сумд нийт 8,975.6 сая төгрөгийн 242 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Сүхбаатар аймгийн Наран сум 300.0 сая төгрөгийн 1 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй, мөн Эрдэнэцагаан суманд хийгдсэн зам засварын ажилд гүйцэтгэгч байгууллагын хийгээгүй ажлыг захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас хийснээр гүйцэтгэлийг баталж, санхүүжилт олгуулсан;
- ✓ Сэлэнгэ аймгийн Ерөө сум 40.0 сая төгрөгийн 1, Орхонтуул 20.0 сая төгрөгийн 1, Сайхан сум 268.0 сая төгрөгийн 3, Хушаат сум 151.3 сая төгрөгийн 3, Цагааннуур сум 27.0 сая төгрөгийн 1, Шаамар сум 13.5 сая төгрөгийн 1, нийт 519.8 сая төгрөгийн 10 ТАХ-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
- ✓ Төв аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Эрдэнэсант, Заамар, Эрдэнэ, Баянхангай сумдад Хүүхдийн автобус хөтөлбөрийн хүрээнд чанарын шаардлага хангахгүй 459.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 автобус хүлээж авсан, мөн 190.8 сая төгрөгийн 2 ТАХ-ний гэрээний хугацаа хэтэрсэн, Шинэ хөдөө төсөл сайн

- үүлдрийн 7 бух худалдан авахад 19.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон гэсэн боловч гүйцэтгэгч болон малчинтай байгуулсан гэрээ байхгүй, данс бүртгэлд тусгаагүй;
- ✓ Увс тодруулах тайланд 1, судалгаанд 50 TAX хяналт хэрэгжүүлээгүй гэж
 - ✓ Ховд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 8,607.2 сая төгрөгийн 27, Алтай сум 77.6 сая төгрөгийн 5, Цэцэг сум 2,118.1 сая төгрөгийн 53, Эрдэнэбүрэн сум 70.0 сая төгрөгийн 1, нийт 10,872.9 сая төгрөгийн 86 TAX-нд захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй;
 - ✓ Хөвсгөл аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2,811.4 сая төгрөгийн 30, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Бүрэнтогтох, Галт, Жаргалант, Их-Уул, Мөрөн, Рашаант, Рэнчинлхүмбэ, Тариалан, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Ханх, Хатгал, Цагааннуур, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сумд 5,370.4 сая төгрөгийн 337, нийт 8,181.8 сая төгрөгийн 367 TAX-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй;

Дээрх алдаа зөрчлөөс гадна захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ “Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл”-ийг дутуу буюу тухайн цаг үеийн агаарын байдал, инженер, даамлаас гүйцэтгэсэн ажлыг шалгаж хүлээн авсан талаар тэмдэглэл, хяналтаар өгсөн зөвлөмж, шаардлагын хэрэгжилт, ил, далд ажлын акт зэргийг тэмдэглэж, баталгаажуулаагүй зөрчил нийтлэг байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас нийт 7,096.9 сая төгрөгийн зөрчилд 1.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5,085.7 сая төгрөгийн 44 албан шаардлага хүргүүлж, 1,549.9 сая төгрөгийн 69 зөвлөмжийг хүргүүлж, 459.8 сая төгрөгийн 1 асуудлын хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Захиалагчийн хяналт хангалтгүйгээс тухайн төсөл, арга хэмжээ чанаргүй, дутуу хийгдэх, зорилтот түвшний үр дүнд хүрэхгүй байх, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүсэж байна.

3.1.3 Өмнөх аудитаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт өгсөн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн төсвийг батлахдаа иргэдийн саналгүй, өргөн мэдүүлсэн төсөл, арга хэмжээг өөрчлөн баталж байгааг таслан зогсоох, хариуцлага тооцох, хууль дээдлэх заалтыг хууль, журамд тусгуулах” зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Харин Сангийн яам болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг даргад өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 85.0 хувьтай байна. (Дэлгэрэнгүйг [хавсралт №-3.1.3-оос харна уу](#))

АНТАГ-ын хэмжээнд “ОНХС-ийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар илэрсэн 162,768.3 сая төгрөгийн зөрчилд тогтоосон 544.8 сая төгрөгийн 62 төлбөрийн актын барагдуулалт 75.9 хувьтай, 76,245.0 сая төгрөгийн 385 албан шаардлагын биелэлт 85.6 хувьтай, 85,908.7 сая төгрөгийн 522 зөвлөмжийн хэрэгжилт 79.5 хувьтай байна. (Дэлгэрэнгүйг судалгаа 7-оос үзнэ үү)

Өнгөрсөн оны аудитаар илэрсэн зөрчилд өгсөн шийдвэрийг Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар, Төв, Увс аймгууд 100 хувь хэрэгжүүлсэн бол бусад аймгууд болон нийслэл бүрэн хэрэгжүүлээгүйгээс шийдвэрийн хэрэгжилт дунджаар 79.1 хувьтай гарч байна.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх оны шийдвэрийн хэрэгжилттэй харьцуулан шинжилбэл:

Хүснэгт №18: Шийдвэрийн хэрэгжилтийн хувь

Тайлант он	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Дундаж хэрэгжилтийн хувь
2023	87.6	86.9	76.4	83.6
2024	75.9	85.6	79.5	79.1

(Эх сурвалж: ОНХС-ийн 2023, 2024 оны судалгаа)

Дээрх хүснэгтээс харахад шийдвэрийн хэрэгжилт өнгөрсөн оноос 4.2 хувиар буурсан нь Төсвийн ерөнхийлөн захирагч нар хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаа нь харагдаж байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ аймаг нь ИТХ-аар төсөв батлуулахдаа техник, эдийн засгийн үндэслэлгүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй ТАХ-г ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн, ажлыг чанаргүй, дутуу хийсэн, гэрээний хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад хяналтыг хэрэгжүүлж ажиллагаагүй шилэн дансны цахим системд мэдээлээгүй, УМС-д мэдээллийг үнэн зөв бүрэн мэдээлээгүй, аймгийн ИТХ-аас хяналт тавьж ажиллагаагүй зэрэг зөрчлүүд давтагдан гарсаар байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх 1,556.2 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 5, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,556.2 сая төгрөгийн 8 албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.

3.2 Удирдлагын мэдээллийн систем, шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн мэдээлэхгүй байгаа нь иргэд олон нийт ил тод, иж бүрэн, үнэн зөв мэдээллийг авч чадахгүй байна

3.2.1 Сум, дүүргийн ЗДТГ-ын дарга нар болон аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайлан, мэдээг “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2³⁹, 9.3⁴⁰, 9.9⁴¹-д заасны дагуу 17 аймаг, 314 сум тайлан, мэдээгээ хүргүүлжээ.

Аймгийн ХБТХОХ-т тайлангаа хүргүүлээгүй 16 сум, ирүүлсэн тайлангаа нэгтгэн дүгнэж, цаашид авах арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргад танилцуулаагүй болон жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлээгүй тус бүр 4 аймаг байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Булган аймгийн Баяннуур, Бугат, Булган, Гурванбулаг, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг сумууд болон Хялганат тосгон, Говь-Алтай аймгийн Дарив, Халиун сум, Дорноговь аймгийн Даланжаргалан, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл, Замын-Үүд, Сайншанд сум журмын 9.2-т заасны дагуу ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг хүргүүлээгүй, Нийслэлийн 9 дүүрэг хүргүүлсэн ч 25-39 хоног хугацаа хоцроосон,
- ✓ Баянхонгор, Говь-Алтай, Орхон, Сэлэнгэ аймгуудын ЗДТГ-ын ХБТХОХ нь сумдаас ирүүлсэн хэрэгжилтийн тайланд журмын 9.3-т заасны дагуу дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэр гаргуулж ажиллагаагүй,
- ✓ Булган аймаг журмын 9.5⁴²-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй,

³⁹ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана

⁴⁰ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

⁴¹ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана

⁴² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ.

- ✓ Говьсүмбэр, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймгууд журмын 9.9-т заасны дагуу хэрэгжилтийн тайланг нэгтгэж Сангийн яамд хүргүүлээгүй

Шийдвэрлэлт: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан Баянхонгор, Говьсүмбэр аймгуудад албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Сайн жишээ: Өвөрхангай аймаг мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор тайлант оны эцэст багийн иргэдийн нийтийн хурал дээр багийн засаг дарга нар тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын тайлангаа танилцуулж хэвшсэн байна. Мөн зарим сумын ЗДТГ-ын фейсбүүк болон цахим хуудсаар дамжуулан тайлангуудыг нээлттэй байршуулж иргэдэд тухай бүр тогтмол мэдээлдэг сайн жишиг тогтсон байна.

Бүрд



Баян-Өндөр



Зүүнбаян-Улаан



Гучин-Ус



3.2.2 Тайлант онд улсын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 523,461.3 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын тогтоол болон Засаг даргын захирамжийг үндэслэн 382,852.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 37,112.9 сая төгрөгийн бараа материалыг тайланд тусгасан бол 72,181.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг урсгал зардлаар тайлагнажээ.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс Нийслэл болон Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд нь данс бүртгэлд бүрэн тусгасан байна. *(Дэлгэрэнгүйг судалгаа 12-оос үзнэ үү)*

Харин нийт 15 аймгийн 14,402.4 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан зөрчил илэрсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг 472.6 сая төгрөг, Баянхонгор аймаг 2,028.0 сая төгрөг, Баян-Өлгий аймаг 248.7 сая төгрөг, Булган аймаг 2,830.7 сая төгрөг, Говь-Алтай аймаг 1,749.2 сая төгрөг, Говьсүмбэр аймаг 456.8 сая төгрөг, Дархан-Уул аймаг 1,503.4 сая төгрөг, Завхан аймаг 147.9 сая төгрөг, Өвөрхангай аймаг 1,063.4 сая төгрөг, Өмнөговь аймаг 488.2 сая төгрөг, Сэлэнгэ аймаг 1,842.7 сая төгрөг, Төв аймаг 686.7 сая төгрөг, Увс аймаг 649.0 сая төгрөг, Ховд аймаг 131.0 сая төгрөг, Хэнтий аймаг 103.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- ✓ Хэнтий аймаг 255.3 сая төгрөгийн хөрөнгийг буруу тайлагнасан байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 11,907.3 сая төгрөгийн зөрчилд 2.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 8,069.7 сая төгрөгийн 34 албан шаардлага хүргүүлж, 3,835.2 сая төгрөгийн 23 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2.3 ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийн зорилго нь:

- ✓ ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлт, бодит, бүртгэл, тайлагналтын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх,

- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, тэдгээрийн санхүүжилт, бүртгэл, тайлагналтыг орон нутгийн хөгжлийн сангийн системээр дамжуулан хэрэгжүүлэх,
- ✓ ОНХС-ийн хөрөнгийн хуваарилалтыг ил тод болгох, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн бодит, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих боломжоор хангах,
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч буй бараа, ажил үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах замаар “шилэн данс”-ны тогтолцоо бүрдүүлэх,
- ✓ Холбогдох байгууллага, албан тушаалтан ОНХС-ийн мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн баримт бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах нөхцөлөөр хангахад чиглэсэн байна.

Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, хяналт, бүртгэлийг “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2⁴³-т заасан хугацаанд удирдлагын мэдээллийн системд оруулах үүрэгтэй.

Улсын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 750,543.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10,942 ТАХ-нээс аймаг, сумдад 677,583.4 сая төгрөгийн 10,413 ТАХ, нийслэлд 72,959.6 сая төгрөгийн 529 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ. Үүнээс 66.6 хувь буюу 7,279 ТАХ-ний талаарх мэдээллийг удирдлагын мэдээллийн системд бүрэн мэдээлсэн бол 14.9 хувь буюу 1,630 ТАХ-г дутуу мэдээлж, 18.5 хувь болох 2,033 ТАХ-г огт мэдээлээгүй байна.

Харин Говьсүмбэр, Сүхбаатар аймгууд удирдлагын мэдээллийн системд оруулбар зохих бүх мэдээллийг бүрэн оруулж тайлагнажээ. (Дэлгэрэнгүйг судалгаа 11-ээс үзнэ үү)

УМС-д байршуулсан ОНХС-ийн талаарх мэдээллийг, АНТАГ-уудын судалгааны дүнтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №19: УМС болон судалгааны мэдээллийн харьцуулалт

(сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Санхүүжилт	Нийт гэрээний дүн	Зарцуулалт	Санал өгсөн иргэд	Ашиглалтад орох ТАХ-ний тоо
1	УМС-д байршуулсан мэдээлэл	137,801.0	-	505,553.0	333,295.0	950,752	7,652
2	АНТАГ-уудын судалгааны мэдээлэл	750,543.1	574,880.9	707,833.2	523,466.5	2,341,082	9,059
3	Зөрүү	(612,728.5)	(574,880.9)	(202,286.6)	(190,171.5)	(1,390,330.0)	(1,407)

Дээрх хүснэгтээс үзэхэд УМС-ийн санхүүжилтийн мэдээлэл байхгүй байгаа нь Төрийн сангийн төлбөр тооцооны FreeBalance системтэй API сервисээр холбогдон гүйлгээний мэдээллийг харилцан солилцдогтой холбоотой, FreeBalance системийн зарим сервис 2024 оноос шинэчлэгдсэн тул УМС-д нэмэлт хөгжүүлэлт хийх шаардлага үүссэн. Иймээс тус системд татагдах шаардлагатай эх үүсвэрүүдийг хөтөлбөр, зориулалтаар нь дахин ангилж, шинэ серверүүдийг бэлтгэн хөгжүүлэлт хийж байна.

Хүснэгт №20: Удирдлагын мэдээллийн системд мэдээлсэн хувь

№	Он	Бүрэн оруулсан ТАХ-ний хувь	Дутуу оруулсан ТАХ-ний хувь	Огт оруулаагүй ТАХ-ний хувь
1	2023	60.8	8.6	30.6


⁴³ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ

2	2024	66.6	14.9	18.5
---	------	------	------	------

Удирдлагын мэдээллийн системд оруулсан ТАХ өмнөх оноос 5.8 хувиар өссөн нь өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласныг харуулж байна.


Дүрслэл №12: Аудитын явцад иргэдээс авсан санал, асуулгын дүн:

4. Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?
18,670 responses



● Байгын иргэдийн нийтийн хурлаас
● Гэр утасны аппликейшн, телевиз, радио, олон нийтийн сүлжээ
● Гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олноос
● Удирдлагын мэдээллийн системээс
● Мэдээлэл авдаггүй

8. Орон нутгийн хөгжлийн сангийн "Удирдлагын мэдээллийн системээс ямар төрлийн мэдээлэл авдаг вэ?"
18,564 responses



● Сангийн хөрөнгийн төлөвлөлттэй холбоотой
● Худалдан авах ажиллагаатай холбоотой
● Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, биелэлттэй холбоотой
● Мэдээлэл авдаггүй

Санал асуулгад хамрагдсан иргэдийн 11.8 хувь нь ОНХС-ийн талаарх мэдээллийг УМС-ээс авдаг гэсэн бөгөөд энэ системээс иргэдийн 60.4 хувь нь ОНХС-ийн төлөвлөлт, худалдан авалт, ТАХ-ний гүйцэтгэл, биелэлттэй холбоотой мэдээллийг авдаг гэж хариулсан байна.

Энэ нь иргэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг удирдлагын мэдээллийн системээр ил, тод нээлттэй авах боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.

Тус системийг иргэд олон нийтэд таниулах ажил хангалтгүй, хүний нөөцийн тогтворгүй байдал, мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтнуудын интернэт орчинд ажиллах чадвар болон программын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаагаас систем бүрэн ашиглагдахгүй байна.

Аудитаар улсын хэмжээнд аймаг, сум, дүүргийн СТСХ, ЗДТГ-ууд нь ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, тайлагналт, бүртгэлийг удирдлагын мэдээллийн системд бүртгэх, иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэх үүргээ хангаж ажиллаагүй дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймаг 472.2 сая төгрөгийн 11 ТАХ-ний мэдээллийг дутуу, 823.9 сая төгрөгийн 44 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Баянхонгор аймаг 15,348.0 сая төгрөгийн 222 ТАХ-ний мэдээллийг дутуу, 2,810.8 сая төгрөгийн 50 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Баян-Өлгий аймаг 815.2 сая төгрөгийн 67 ТАХ-ний мэдээллийг дутуу, 1,309.7 сая төгрөгийн 138 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Булган аймаг 1,950.9 сая төгрөгийн 8 ТАХ-ний мэдээллийг дутуу, 5,994.1 сая төгрөгийн 40 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Говь-Алтай аймаг 611.2 сая төгрөгийн 34 ТАХ-ний мэдээллийг дутуу, 1,572.6 сая төгрөгийн 95 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Дархан-Уул аймаг 3,706.3 сая төгрөгийн 34 ТАХ-ний мэдээллийг дутуу, 2,374.9 сая төгрөгийн 33 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Дорноговь аймаг 7,328.1 сая төгрөгийн 41 ТАХ-ний мэдээллийг дутуу, 17,309.3 сая төгрөгийн 125 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Дорнод аймаг 1,496.6 сая төгрөгийн 19 ТАХ-ний мэдээллийг дутуу, 4,998.8 сая төгрөгийн 60 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Дундговь аймаг 5,498.1 сая төгрөгийн 107 ТАХ-ний мэдээллийг дутуу, 3,364.0 сая төгрөгийн 71 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Завхан аймаг 57.4 сая төгрөгийн 3 ТАХ-ний мэдээллийг дутуу, 2,062.3 сая төгрөгийн 105 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Орхон аймаг 23,290.6 сая төгрөгийн 135 ТАХ-ний мэдээллийг дутуу, 6,065.1 сая төгрөгийн 25 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,

- ✓ Өвөрхангай аймаг 2,383.4 сая төгрөгийн 32 ТАХ-ний мэдээллийг дутуу, 1,066.6 сая төгрөгийн 41 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Өмнөговь аймаг 20,732.4 сая төгрөгийн 76 ТАХ-ний мэдээллийг дутуу, 12,794.4 сая төгрөгийн 114 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Сэлэнгэ аймаг 2,065.2 сая төгрөгийн 13 ТАХ-ний мэдээллийг дутуу, 2,218.2 сая төгрөгийн 29 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Төв аймаг 16,848.9 сая төгрөгийн 206 ТАХ-ний мэдээллийг дутуу, 8,871.7 сая төгрөгийн 167 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Увс аймаг 4,422.4 сая төгрөгийн 2,024 ТАХ-ний мэдээллийг дутуу, 1,405.0 сая төгрөгийн 41 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Ховд аймаг 19,319.8 сая төгрөгийн 213 ТАХ-ний мэдээллийг дутуу, 18,637.4 сая төгрөгийн 248 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Хөвсгөл аймаг 248.0 сая төгрөгийн 20 ТАХ-ний мэдээллийг дутуу, 1,177.3 сая төгрөгийн 61 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Хэнтий аймаг 13,087.7 сая төгрөгийн 195 ТАХ-ний мэдээллийг дутуу, 1,768.8 сая төгрөгийн 57 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй,
- ✓ Нийслэл 63,947.7 сая төгрөгийн 489 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 17,340.5 сая төгрөгийн зөрчилд 10,287.5 сая төгрөгийн 15 албан шаардлага хүргүүлж, 7,052.9 сая төгрөгийн 45 зөвлөмж хүргүүлсэн байна.

“ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 10 дугаар зүйлийн 10.3.3⁴⁴-т заасан заалтыг шат шатандаа хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь УМС-д ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, хяналт бүртгэлийн мэдээллийг бүртгээгүй зөрчлүүд давтагдсаар байна.

3.2.4 Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2⁴⁵, 6 дугаар зүйлийн 6.1.1⁴⁶, 6.3.9⁴⁷, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 11 дүгээр хавсралтад заасан агуулгын хүрээнд www.shilendans.gov.mn цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, сарын гүйцэтгэлийг дараа сарын 8-ны өдрийн дотор тогтмол мэдээлэхээр заасан.

Аудитаар аймаг, нийслэл, сум дүүргийн ЗДТГ-ын ОНХС хариуцсан албан тушаалтнууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2024 оны ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг дутуу оруулсан, хугацаа хоцроож мэдээлсэн, огт мэдээлээгүй зөрчлүүд гарсан байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- ✓ Архангай аймгийн Цэцэрлэг, Өндөр-Улаан, Булган сум 304.2 сая төгрөгийн 15 мэдээллийг байршуулаагүй,
- ✓ Говь-Алтай аймгийн Дарив, Дэлгэр, Жаргалан, Төгрөг, Халиун, Шарга, Эрдэнэ сум 72 мэдээлэл дутуу, 40 мэдээлэл огт мэдээлээгүй,
- ✓ Дархан-Уул аймаг 261.3 сая төгрөгийн 3 ТАХ-ний зарцуулалтыг мэдээлээгүй,

⁴⁴ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй;

⁴⁵ Орон нутгийн хөгжлийн сан

⁴⁶ тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор

⁴⁷ орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

- ✓ Дорнод аймгийн Дашбалбар сум 7, 9 дүгээр сар, Чулуунхороот сум 1-4 дүгээр сар, Сэргэлэн сум 7 дугаар сар, Халх гол сум 2 дугаар саруудын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Гурванзагал сум 1-12 дугаар саруудын мэдээлэл оруулаагүй,
- ✓ Дундговь аймаг 75, Өлзийт сум 15, Луус сум 5 мэдээллийг хугацаа хоцроосон бол Сайхан-Овоо сум 33, Өлзийт сум 28 мэдээллийг огт байршуулаагүй,
- ✓ Сэлэнгэ аймаг 2 мэдээллийг хугацаа хоцроож, 17 сум 72 мэдээллийг хугацаа хоцроож, 122 мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн бол 23 мэдээллийг огт мэдээлээгүй,
- ✓ Сүхбаатар аймаг болон Баяндэлгэр сум тендерийн ерөнхий мэдээллийг огт байршуулаагүй, харин Онгон, Сүхбаатар, Баруун-Урт сумууд тендерийн ерөнхий мэдээллийг дутуу байршуулсан,
- ✓ Увс аймгийн Бөхмөрөн, Завхан сумдад шилэн дансны цахим хуудсанд 2,623.7 сая төгрөгийн мэдээлэл байршуулаагүй байна.

Шийдвэрлэлт: АНТАГ-аас дээрх нийт 2,885.0 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 2,885.0 сая төгрөгийн 16 зөвлөмж хүргүүлсэн байна.

Шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг хугацаа хоцроосон, дутуу мэдээлсэн, мэдээллийг бүрэн байршуулаагүй зэрэг зөрчил нь иргэд, олон нийт үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээллээр хангагдахгүй байх сөрөг үр дагавартай байна.



Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

26-94



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР,
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА

2026.01.06 № 03172
танай _____ -ны № _____ -т

Санал хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газраас “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайлангийн төслийн Сангийн яаманд өгч буй зөвлөмжийн 4-д “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, СХДАГ-аас хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүйд хариуцлага тооцох талаар заасан байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11.1, 11.2-т хариуцах эзэн, хүлээх хариуцлагыг тусгасан.

Иймд Үндэсний аудитын газраас “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийн Сангийн яаманд өгч буй 4 дүгээр зөвлөмжийг хасуулах саналтай байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


М.БАЯРМАГНАЙ

9766000139

Аудитын тайлангийн төсөлд холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар:

№	Тайлангийн төслийн дугаар, утга	Асуудал хариуцсан байгууллага, нэгж	Гаргасан санал, тайлбар	Аудитын тайлбар
1	Сангийн яаманд: “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, СХДАГ-аас хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүйд хариуцлага тооцох талаар тодорхой тусгах	Монгол Улсын Сангийн яам	Аудитын тайлангийн төслийн Сангийн яаманд өгч буй зөвлөмжийн 4-д “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, СХДАГ-аас хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүйд хариуцлага тооцох талаар заасан байна. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11.1, 11.2-т хариуцах эзэн, хүлээх хариуцлагыг тусгасан. Иймд Үндэсний аудитын газраас “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийн Сангийн яаманд өгч буй 4 дүгээр зөвлөмжийг хасуулах саналтай байна.	Саналыг хүлээн авсан. 1.Сангийн яаманд хүргүүлэх “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, СХДАГ-аас хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүйд хариуцлага тооцох талаар тодорхой тусгах” гэсэн зөвлөмжийг хасав. 2.Зөвлөмжийг хассантай холбоотой аудитын тайлангийн төслийн 3.1.1-д “Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, СХДАГ-аас хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүйд тооцох хариуцлагын талаар заалт байхгүйгээс жил бүр аудитаар илрэх зөрчлийн тоо буурахгүй байгаа тул тус асуудлыг Сангийн яаманд зөвлөмжөөр хүргүүлэв” гэснийг хасав

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. ОНХНС-д 2024 оны сүүлээр төвлөрсөн ГНАТ-ийн орлогыг аймаг, нийслэлд хуваарилаагүйгээс төлөвлөсөн орлого тасрахад нөлөөлжээ.
2. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг хуваарилахдаа зарим сум, дүүргийн ОНХС-д 435.9 сая төгрөг илүү олгосон байна.
3. ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлсэн хэдий ч орон нутгийн нэмж төлөвлөсөн эх үүсвэрийн бүрдүүлэлт хангалтгүй байна.
4. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн ч иргэдийн саналаар дэмжигдээгүй, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталдаг зөрчил давтагдсаар байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 750,459.9 сая төгрөгийн 10,942 ТАХ-ний 26.1 хувь буюу 209,029.6 сая төгрөгийн 916 ТАХ бүрэн хэрэгжээгүй байна.
6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 523,461.3 сая төгрөгийн 8,998 ТАХ-ний 2 хувь буюу 17,772.6 сая төгрөгийн 180 ТАХ нь журамд заасан чиг үүрэгт хамааралгүй, урсгал зардлын шинжтэй 84,552.3 сая төгрөгийн ТАХ-г санхүүжүүлсэн байна.
7. Захиалагчаас төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлага, хүртэх үр өгөөжийг тооцоолоогүй, гүйцэтгэгч нар ажил, үйлчилгээг чанаргүй гүйцэтгэснээс зарим аймагт ашиглалтгүй хөрөнгүүд бий болж байна.
8. Холбогдох албан тушаалтны хяналт сул байгаагаас эд хөрөнгө эвдэрч, гэмтэх, зориулалт бусаар ашиглах зэрэг алдаа зөрчил давтагдсанаар үр ашиггүй зардал гарч байна.
9. Удирдлага мэдээллийн систем болон шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн оруулаагүйгээс иргэд, олон нийт ил тод, үнэн зөв мэдээллийг авч чадахгүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЕ ШАТНЫ АЖИЛД АЛБАН ТУШААЛТНУУДЫН ТАВИХ ХЯНАЛТ СУЛ, ХАРИУЦЛАГАГҮЙ БАЙДЛААС САНГИЙН ХӨРӨНГИЙН ҮР ӨГӨӨЖ, ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ БАЙНА

АНТАГ аудитаар нийт 158,461.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 956.2 сая төгрөгийн 75 төлбөрийн акт тогтоож, 109,352.8 сая төгрөгийн зөрчилд 613 албан шаардлага хүргүүлж, 46,010.0 сая төгрөгийн зөрчилд 702 зөвлөмж өгч, 2,142.6 сая төгрөгийн 8 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч ажиллахыг зөвлөж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг бүсчлэн нэгдсэн байдлаар тогтоож Төсвийн тухай хууль болон Малын тоо толгойн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг авч хэлэлцэх,

САНГИЙН ЯАМАНД:

1. ОНХНС-д төвлөрсөн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг аймаг, нийслэлд олгохдоо Сангийн сайдын 2021 оны “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу сумдын орлогын гүйцэтгэлд үндэслэн шилжүүлэх,
2. “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос ОНХС-д олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолд нийцүүлэн шинэчлэн батлуулах,
3. ОНХНС-аас санхүүжилтийг олгохдоо “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.3 дахь заалтын дагуу тухайн зөрчлийг бүрэн арилгах хүртэл санхүүжилтийг олгохгүй байх арга хэмжээг авч ажиллах,

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ:

1. ОНХНС-т хуваарилах газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогыг үнэн зөв алдаагүй тооцоолж байх

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-Д:

1. Иргэдийн саналаар дэмжигдээгүй, Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан шаардлагад нийцээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг батлахгүй байх
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, бүртгэлд тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлж байх

АЙМАГ НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүй ТАХ-г төлөвлөхгүй байх,
2. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.3, 3.4-т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллах,
3. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4, 9.5-т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, дүн шинжилгээ хийж ажиллах,

Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5⁴⁸-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 06 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
2026.01.19

⁴⁸ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

